

**ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2018.07.01

Булган сум

**Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**-Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын болон захиргааны үйл ажиллагааны баримт бичгийн зүйл, заалтын хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж, хангаж буй талаар товч тусгах:**

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2017 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн Б\01 дүгээр тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагаас 2018 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан Цагдаагийн газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган Цагдаагийн газрын даргаар батлуулж биелэлт, үр дүнг тооцон ажилласан.

Цагдаагийн газраас Монгол улсын хууль, тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Захиргааны хэм хэмжээний акт, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хоёр дахь хөтөлбөр, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратегийг хэрэгжүүлэх хөтөлбөр, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний 2 дахь хөтөлбөр, Гэрч хохирогчийг хамгаалах, тусламж үзүүлэх үндэсний хөтөлбөр, Хөгжлийн зам үндэсний хөтөлбөр, Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2018-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2016-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөгөө, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2018-2019/, 2018 онд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө арга хэмжээний нэг дэх үе шатны төлөвлөгөө /2017-2019/, Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх төлөвлөгөө, Цагдаагийн байгууллагаас Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, тогтолцооны харилцан үнэлгээний үр дүнг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Хүний эрхийн үндэсний комисс, ЦЕГ-ын даргын хооронд байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/46-р тушаалыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр хэрэгжүүлэх төлөвлөгөө, “Эрүүл-цагдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал, шийдвэр, зөвлөмж, албан даалгавар, өгсөн үүрэг, ажлын чиглэл, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, шийдвэр, баталсан хөтөлбөр, төлөвлөгөө, өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт, тушаал шийдвэр, хөтөлбөр төлөвлөгөөний биелэлтүүдийг заасан хугацаанд тухай бүр нь хяналт шинжилгээ үнэлгээ хийж холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна.

2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн Цагдаагийн газрын даргын А/26 дүгээр тушаалаар “Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх” 64 баримт бичгийн жагсаалтыг гаргаж батлуулан хэрэгжилтэнд нь хяналт тавьж, 2018 оны 05 дугаар сарын 01, 05-ны өдөр, 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрүүдэд 12 биелэлтийг гарган холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргын 2018 оны 06-р сарын 05-ны өдрийн 5/170 тоот албан бичгээр ирүүлсэн 2018 оны 01 дүгээр улирлын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний талаарх мэдээлэл, ажлын чиглэлд заасан зөрчлийг арилгаж, Цагдаагийн ерөнхий газрын даргын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн даргын 2018 оны 04-р сарын 23-ны өдрийн 5а/2414 тоот албан бичгээр ирүүлсэн “Зөвлөмж”-ийг хэрэгжүүлж ажиллалаа.

**-Байгууллагын даргын зөвлөлийн хуралдаан тайлангийн хугацаанд хуралдсан байдал, шийдвэрлэсэн асуудлыг багцлан тусгах:**

2018 оны эхний хагас жилийн байдлаар цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурал нийт 8 удаа хуралдаж удирдлага зохион байгуулалтын чиглэлээр 31, хүний нөөцийн чиглэлээр 61 асуудал, сахилга хуриуцлагын чиглэлээр 9 асуудлаар сонсгол мэдээлэл оруулан хэлэлцэж шийдвэр гаргасан байна.

**-Хүний нөөцийн бодлогын талаар товч тусгах. /Томилогдсон, чөлөөлөгдсөн, хүний нөөцийн нөхөн хангалт хийсэн, батлагдсан орон тоо, дутуу орон тоо гэх мэт/**

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/248 дугаар тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-909/-ын дагуу Тус цагдаагийн газар нь 2018 оны эхний хагас жилийн байдлаар Рашаант сум дахь сум дундын цагдаагийн тасгийн цагдаа-зохицуулагчийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Б/180 дугаар тушаалаар Рашаант сум дахь сум дундын цагдаагийн тасгийн Баяннуур сум дахь зохицуулагчаар, Эрүүгийн цагдаагийн тасгийн жижүүрийн ахлах офицерыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Б/288 дугаар тушаалаар Хутаг-Өндөр сум дахь сум дундын цагдаагийн тасгийн даргаар, Хишиг-Өндөр сум дахь сум дундын цагдаагийн тасгийн Гурванбулаг сумын хэсгийн төлөөлөгчийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн Б/391 дүгээр тушаалаар Эрүүгийн цагдаагийн тасгийн жижүүрийн ахлах офицероор томилон, цагдаагийн хошууч цолоор шагнаж, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагчийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 06 сарын 12-ны өдрийн Б/ 428 дугаар тушаалаар Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэнээр тус тус дэвшүүлэн томилуулсан.

2018 оны хагас жилийн байдлаар саатуулах байрны эмчийн сул орон тоонд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Б/180 дугаар тушаалаар Л.Отгонтөгийг саатуулах байрны эмч-дадлагажихаар, Цагдаагийн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн А/13 дугаар тушаалаар цагдаагийн дэд ахлагч А.Олонбаярыг хамгаалалтын цагдаагаар, 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/27 дугаар тушаалаар цагдаагийн дэд ахлагч Г.Түвшинтгөсийг эргүүлийн цагдаагаар, 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн Б/06 дугаар тушаалаар цагдаагийн дэд ахлагч Б.Мөнхболдыг эргүүлийн цагдаагаар, цагдаагийн дэд ахлагч Г.Дэмбэрэлдоржийг цагдаа-жолоочоор тус тус томилж ажлын байраар ханган ажилласан байна.

**-Алба хаагчдын дунд зохион байгуулсан албаны сургалт, түүний үр дүнгийн талаар:**

Тус Цагдаагийн газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/02 дугаар тушаалаар “Албаны сургалтын календарчилсан төлөвлөгөө”-г батлан долоо хоног бүрийн “Мягмар” гарагийн өглөөний 08 цагаас албаны сургалтыг зохион байгуулж хэвшсэн.

Тус газрын 2018 оны албаны сургалтын нээлтийг хийж Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш сурган хүмүүжүүлэх ухааны доктор, Монголын эмэгтэй эрдэмтдийн холбооны Орхон аймаг дахь салбарын тэргүүн, Монголын эмэгтэй эрдэмтдийн холбооны нарийн бичгийн дарга Б.Энхцэцэгийг урьж **“Харилцаа, өөрийгөө илэрхийлэх чадвар”** сэдэвт 2 цагийн сургалтанд 104 алба хаагч, Орхон аймгийн

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш н.Алтанцэцэгийг урьж **“Харилцааны соёл”** сэдэвт 3 цагийн сургалтанд 110 алба хаагчид тус тус хамрагдсан.

2018 эхний хагас жилийн байдлаар тус газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах байцаагч **“Зөрчлийн тухай хууль”**, **“Гэр бүлийн харилцаа”** сэдвүүдээр 60 алба хаагчид 1 цаг 30 минутын сургалтыг орж, 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 9/53 дугаартай албан бичгээр Цагдаагийн Ерөнхий Газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн даргаас ирүүлсэн **“Гэмт хэргээс урдчилан сэргийлэх тухай хууль”**-ийг алба хаагчдаараа судлуулахаар ирүүлсэнийг уншиж сонсон гэрийн даалгаварт өгч судлуулахаар даалгасан.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэргэжилтэн **“Шинээр батлагдсан багц хуулийн талаар мэдээлэл”**, Хөдөлмөр нийгмийн халамжийн газрын Халамжийн хэлтсийн дарга **“Шинээр батлагдсан Халамжийн тухай хууль”**, Скайтел Булган аймаг дахь салбараас шинээр гаргасан ажлын санал”-ыг тус тус 64 алба хаагчид 2 цагийн хугацаанд танилцуулсан.

Аймгийн шүүхийн Эвлэрүүлэн зуучлах албаны шүүгч **“Эвлүүлэн зуучлах ажиллагаа, гэр бүлийн харилцаа”** сэдэвт сургалтыг 60 алба хаагчид 1 цагийн сургалт,

Хүний эрхийг хамгаалах комиссийн гишүүн, аймгийн хүний эрхийн комиссийн мэргэжилтэн нарыг урьж **“Хүний эрхийн талаархи зарим асуудал”** сэдэвт сургалтыг 54 алба хаагчид 2 цагийн сургалт,

Эрүүгийн ахлах мөрдөгч **“Бусдын хууль бус үйл ажиллагааг хаацайлдаг, хамгаалдаг, ашиг сонирхлын зөрчлийг эсрэг, хувийн сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн мэдээллийн систем”** сэдвээр 53 алба хаагчдад 2 цагийн сургалт,

Замын цагдаагийн тасгийн ахлах байцаагч **“Албаны бэлэн байдал, жолоочийн ажлын уялдаа, нэгдмэл байдлыг хангах нь”**, **“Цагдаагийн ажилтаны хувийн зохион байгуулалт”**, **“Орон нутгийн замд зам тээврийн осол хэргийг бууруулах шалтгаан нөхцөл, цаашид авах арга хэмжээ”** сэдэвт сургалтуудыг 58 алба хаагчид 2 цагийн сургалт,

Цагдаагийн газрын сэтгэл зүйч, эрүүгийн мөрдөгч нар хамтран **“Цагдаагийн алба хаагчийн харилцаа”**, **“Уур, уур”**, **“Гэр бүлийн харилцаа”** сэдвээр 56 алба хаагчид 2 цагийн сургалт,

Нэгдсэн эмнэлгийн яаралтай түргэн тусламжийн эмчийг урьж **“Эрүүл зөв хооллолт”** сэдвээр 1 удаагийн 1 цагийн сургалтыг 54 алба хаагчдад, мөн эмнэлгийн цусны төвийн бага эмчийг урьж **“Цусны бүлэг тодорхойлох”** сэдвээр 1 удаагийн 1 цагийн сургалтыг 60 алба хаагчдад орж сургалт,

Олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах мэргэжилтэн **“Сургалт явуулах арга зүй”** сэдэвт сургалтыг нийт 58 алба хаагчид 2 цагийн сургалт,

Хүний нөөцийн мэргэжилтэн, Холбоо мэдээллийн инженер нар **“Мэдээллийн аюулгүй байдал”**, **“Хүний нөөцийн аюулгүй байдал”** сэдэвт сургалтуудыг 40 алба хаагчид 3 цагийн сургалт,

Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч Хүний эрхийн сургагч багшаар бэлтгэгдэн ирж **“Хүний эрхийн үндсэн ойлголт”** сэдэвт сургалтыг 55 алба хаагчид 2 цагийн сургалт.

Эрүүгийн цагдаагийн тасгийн мөрдөгч **“Цагдаагийн байгууллагын алба хаагчдаас гадаадын иргэд, байгууллагатай харилцах нь”** сэдэвт сургалтыг 58 алба хаагчид 2 цагийн сургалтуудыг тус тус зохион байгуулсан.

2018 оны 03 дугаар сарын 13-ны өдөр тус газрын мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн **“Санд ажиллах аргачлал, заавар”** сэдэвт сургалтыг 54 алба хаагчид 1 цагийн сургалтын орж алба хаагчдаар дадлагажуулах ажлыг зохион байгуулсан. Мөн цагдаагийн газрын алба хаагч нарыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-205 / бие даан судлуулахаар гэрийн даалгаварт өгч тестийн шалгалтаар болон сургалтын дэвтэр хөтөлсөн байдлаар нь дүгнэсэн.

2018 оны эхний хагас жилийн байдлаар тус газрын алба хаагчдаас удаа тестийн шалгалт авч, албаны сургалтын дэвтэрийг 4 удаа шалган тестийн шалгалтанд хангалтгүй үнэлгээ авсан 14 алба хаагчийн цалинг 5 хувь, сургалт тасалсан 6 алба хаагчийн цалинг 10 хувь, сургалтын дэвтэрт хангалтгүй, тэмдэглэл дутуу хөтөлсөн 5 алба хаагчийн цалинг 5-15 хувь үр дүнгээр нь улирлын байдлаар хасаж үүрэг чиглэл өгсөн.

2018 оны 01 дүгээр улиралд тус газрын сургагч багш нараас давхардсан тоогоор 301 алба хаагчид 8 цагийн сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран давхардсан тоогоор 404 алба хаагчид 7 цагийн сургалтыг тус тус зохион байгуулсан.

Цагдаагийн газрын 2017 оны нэгдсэн сургалт зөвлөгөөнийг 2018 оны 01 дүгээр сард, 2018 оны 01 дүгээр сарын нэгдсэн сургалт зөвлөгөөнийг мөн оны 04 дүгээр сард тус тус зохион байгуулсан. Нэгдсэн сургалт зөвлөгөөний үеэр Аймгийн прокурорын газар, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газар, аймгийн Онцгой байдлын газар, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Орхон аймгийн шинжлэх ухаан технологийн их сургуультай хамтран нийт бие бүрэлдэхүүнд 10 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран алба хаагчдын мэргэшүүлэх, сургагч багш бэлтгэх сургалтанд хамруулах ажлыг тасралтгүй зохион байгуулан ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын төвд давтан болон мэргэшүүлэх сургалтанд хамрагдах алба хаагчдын нэрсийг гарган хүргүүлж нийт 37 алба хаагчийг сургалтанд хамруулсан. Мөн Хууль сахиулахын их сургуулийн эчнээ 5 болон 3 жилийн сургалтанд 4 алба хаагчийг суралцуулж шинээр суралцах хүсэлт гаргасан 6 алба хаагчийн хүсэлтийг дэмжин суралцах нөхцөлөөр хангасан.

IDLO төрийн бус байгууллага, Хүний эрхийн үндэсний комисстой хамтран хэсгийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, хэсгийн байцаагч зэрэг 12 алба хаагчийг “Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх” сургалтанд хамруулсан.

### **-Алба хаагчдын нийгмийн асуудал, үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар тусгах:**

Цагдаагийн Ерөнхий Газрын Санхүү аж ахуйн албаны даргын 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 6/450 дугаартай албан бичгээр ирүүлсэн Улаанбаатар хот Баянзүрх дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр Хангалт үйлчилгээний төвийн урьд талд байрлах “Цагдаа-Амгалан” хотхоны хоёр дахь ээлжийн 270 айлын орон сууцанд тус Цагдаагийн газраас 9 алба хаагч санал өгсөнийг ирүүлсэн хавсралт хүснэгтийн дагуу судалгааг 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 34/04-563 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Цагдаагийн Ерөнхий Газар, ХААН банк хамтран ажиллах гэрээнд заасны дагуу орон сууцны 1.2 хувийн хүүтэй зээлд хамрагдсан нэр бүхий 4 алба хаагчийг 0.8 хувийн хүүтэй орон сууцны зээлд шилжүүлэн өгөх хүсэлтийг ХААН банкины Булган салбарын захиралд 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр 38/01-1480 дугаартай албан бичгээр хүргүүлэн ажилласны үндсэн дээр 2 алба хаагчийн орон сууцны 1.2 хувийн хүүтэй зээлийг 0.8 хувьд шилжүүлсэн болно.

Тус газрын Жижүүрийн шуурхай албанд хөдөө дуудлаганд явах хурд хүч сайтай УАЗ маркын ОХУ-д үйлдвэрлэсэн фургон автомашиныг аймгийн Засаг даргын Тамгын газраас 38.0 сая төгрөгийг шийдвэрлүүлэн, авто машинд тусгай дуут дохио “GPS” төхөөрөмж, машины станц, лед гэрэл, шөнийн дуран, мөрдөгчийн хэргийн газрын үзлэгийн цүнх, машины доторлогоо хийж тоноглолын хамт 2018 оны 5-р сарын 27-ны өдөр худалдан авч парк шинэчлэлт хийж ажилласан.

Тус Цагдаагийн газрын 70 алба хаагчид “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хуудас”-ыг шинээр нээж үзлэгт хамруулсан.

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын баталсан “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хүрээнд Цагдаагийн газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн Б/62 дугаар тушаалаар тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг томилж, 21 заалт бүхий салбар төлөвлөгөө гарган үр дүнг тооцон ажиллаж байна.

Мөн тус газраас Аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан байгууллагын дарга нараар батлуулж, алба хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж, үзлэг оношлогоо, эмчилгээ сувилалд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Булган аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран тус Цагдаагийн газрын алба хаагчдад элэгний “В”, “С” вирусын шинжилгээг авч, элэг хамгаалах 1,2,3 дүгээр тунгийн вакцинд хамруулан ажиллаж 3 алба хаагчийг “С” вирусын эмчилгээнд хамруулсан.

Мөн Аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран “Шүд эрүүл бол бие эрүүл” сэдэвт сургалтыг төвийн алба хаагчдын дунд зохион байгуулж, үзлэг, оношилгоо хийж, 21 алба хаагчийг шүдний эмчилгээнд хамруулсан.

Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн яаралтай түргэн тусламжийн эмч А.Наранхүүг урьж “Эрүүл зөв хооллолт” сэдвээр 1 удаагийн 1 цагийн сургалтыг 54 алба хаагчдад, мөн эмнэлгийн цусны төвийн бага эмч Т.Туяаг урьж “Цусны бүлэг тодорхойлох” сэдвээр 1 удаагийн 1 цагийн сургалтыг 60 алба хаагчдад сургалтыг зохион байгуулсан.

Булган аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран хачигний эсрэг 3 дахь тунгийн вакцинд төвийн 30 алба хаагчдыг бүрэн хамруулан ажилласан.

2018 онд тус Цагдаагийн газрын 80 жилийн ой тохиох учир алба хаагчдын нийгмийн баталгаа, ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор “Булган цагдаа 80-Бүтээлч ажил” аяныг эхлүүлсэнийг эрчимжүүлж 2018 оны 03-р сарын 27-ны өдөр Цагдаагийн газрын даргын А/21 дүгээр тушаал гарган Цагдаагийн газрын түүхт 80 жилийн ойг зохион байгуулах ажлын хэсгийг томилж, мөн даргын А/20, А/22, А/23, А/24 дугаар тушаалуудаар төлөвлөгөөний дагуу ажлын дэд хэсгүүдийг байгуулж, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар шинэлэг санаа, арга барил, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, алба хаагчдын нийгмийн асуудал, ажиллах нөхцөл бололцоог дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээг зохион байгуулах, иргэд олон нийттэй хамтран ажиллах, тэдний дэмжлэг туслалцааг авах, идэвхи санаачлагыг өрнүүлэх, байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаа, ажлын ололт амжилт, үр дүнгийн талаар олон нийтэд сурталчилах, алба хаагчдын сахилга ёс зүйн байдлыг дээшлүүлэх чиглэлүүдээр тодорхой арга хэмжээнүүдийг төлөвлөн 2018 оны 06-р сарын 31-ний өдөр нэгтгэн дүгнэхээр ажиллаж байна.

Улсын Ерөнхий Прокурорын 2017 оны 06-р сарын 27-ны өдрийн А/57 тоот “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага батлах тухай” тушаалаар батлагдсан стандарт нөхцлийг хангасан өрөөг 2018 оны 1-р сарын 19-ний өдөр дуусгаж, ашиглалтанд хүлээн авснаар шинэчлэн батлагдсан хуулийн хэрэгжилт хангагдсан.

Мэдүүлэг авах өрөөнд 2 ширхэг компьютер, 4 ширхэг хяналтын камер, 2 ширхэг принтер, 2 ширхэг тог баригч, камерын төхөөрөмжүүдийг угсарч хэвийн ажиллагаанд оруулсан.

Эд мөрийн баримт, граж, склад зэргийг хянах 3 ширхэг камер суурилуулан ЖША-ны хяналтын дэлгэцэнд хяналтыг холбож ажилласан.

Эрүүгийн цагдаагийн тасгийн гадна хаалгыг тусгай картаар онгойх зориулалт бүхий соронзон түгжээг байрлуулсан.

Цагдаагийн Ерөнхий Газрын Санхүү аж ахуйн албанаас “Делл” маркын иж бүрэн 4 суурин компьютерийг 2 принтерийн хамт шийдвэрлүүлэн мөрдөн байцаагч нарын албан хэрэгцээнд өгсөн.

Хангал суман дахь сум дундын цагдаагийн тасгийн Хялганат тосгон дахь цагдаагийн албанд захирагчийн албаны нөөц хөрөнгөнөөс 5,0 төгрөгийн шийдвэрлэн албан хэрэгцээнд прус-11 маркын худалдан авч өгсөн.

**-Нутаг дэвсгэрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар уламжлан шийдвэрлүүлсэн ажил, арга хэмжээ, төсөв, хөрөнгө, зарцуулалт, үр дүнгийн талаар тусгах:**

Аймаг, сумын Засаг дарга, ИТХ, ГХУСА33, салбар зөвлөлийн хуралд тус газрын алба хаагчдаас нийт 54 удаа гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар танилцуулж, танилцуулганд 57 асуудал шийдвэрлүүлэхээр санал оруулсны 35 буюу 61,4 хувийг дэмжин тодорхой төсвийг шийдвэрлэж өгсөн байна. Тухайлбал: Хишиг-өндөр, Могод сумдад шинээр камер нэмж тавиулах 8,000,000 төгрөг, Баяннуур сум замын хажууд байрлуулах зурагт самбар хийлгэх 500,000 төгрөг, бусад сумд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж, сэрэмжлүүлэг хэвлүүлэх, тэмцээн, уралдаан зохиох, кобан байрны засвар тохижилт, автомашины сэлбэг, хяналт шалгалт, сургалтын шатахууны зардал зэрэгт 4,799,000, олон нийтийн эргүүлд сайн ажилласан байгууллагуудыг урамшуулах 450,000 төгрөг, Илтгэлийн уралдааны урамшууллын зардал 300,000, Рашаант сумын авто замын тэмдэг, тэмдэглэгээ хийх 3,000,000, Захиргааны хяналтанд

байгаа хүмүүсийг хамруулан явуулсан “Итгэл бэлэглэе” арга хэмжээний зардал 1,200,000 төгрөгийг тус тус аймаг, сумын ГХУСАЗЗ-өөс санхүүжүүлсэн байна.

Авто зам дагуу хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэж байгаа 5 постонд Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 2,700,000 төгрөг шийдвэрлүүлэн нарны гэрлээр ажиллах туузан гэрлийг хятад улсаас захиалан авчруулж байрлуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд тус газраас "Олон нийтийн цагдаа нарын хувцасны зардал шийдвэрлүүлэх тухай", "Цагдаагийн газрын үйл ажиллагааны эмхэтгэл хэвлүүлэх нь", "Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зам тээврийн осол хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудал", "Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдэгдэн гарч буй гэмт хэрэг, зөрчил, цаашид анхаарах асуудал" сэдвээр тус тус мэдээлэл хийж, хэлэлцүүлэн Олон нийтийн цагдаа нарын хувцасны зардал, Цагдаагийн газрын 2017 оны үйл ажиллагааны эмхэтгэл хэвлүүлэх зардлыг аймгийн Засаг даргын нөөцөөс 1.775.0 мянган төгрөгийг шийдвэрлүүлсэн.

Хутаг-өндөр сум дахь сум дундын Цагдаагийн тасгаас санаачлан "Гацуурхан" цэцэрлэг, сумын ЗДТГ-тай хамтран сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд замын хөдөлгөөний дадал соёл эзэмшүүлэх зорилгоор цэцэрлэгийн гадна “мини дром” хийж ашиглалтанд оруулсан..

Булган сумын төвд байгаа гэрэлтүүлгийг 2018.02.14-ний өдөр Хот тохижилт үйлчилгээний ангитай хамтарч үзлэг шалгалтыг хийхэд нийт 624 гэрэлтүүлэг байхаас асч байгаа 478 гэрэлтүүлэг байсныг Хот тохижилт үйлчилгээний ангиар засварлуулж хэвийн үйл ажиллагаанд оруулсан.

Булган аймгийн Цагдаагийн газраас сумдын Засаг дарга, сум дундын цагдаагийн тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нартай 2018 онд хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулж, аймгийн эрүү хэв журмын нөхцөл байдал, хэрэг бүртгэлтийн ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээл, анхаарах асуудлаар мэдээлэл хийж, хэсэгчилсэн урлагийн тоглолтоор мэндчилгээ дэвшүүлээ. Мөн энэ үеэр 2017 оны гурвалсан гэрээний биелэлт, үр дүнг тооцож гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутагтаа үр дүнтэй ажил зохион байгуулсан Рашаант сумын Засаг дарга Ш.Бат-эрдэнэ, Дашинчилэн сумын Засаг дарга Д.Луттөмөр, Тэшиг сумын Засаг дарга Б.Батсайхан, Хангал сум дахь сум дундын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Л.Батбилэг, Дашинчилэн сумын Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Э.Энхболд нарыг Цагдаагийн газрын “Баярын бичиг”, дурсгалын зүйлээр, Бугат сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Б.Энхтөрийг Эрүүгийн цагдаагийн албаны “Баярын бичиг”-ээр, бусад сумдын Засаг дарга нарт “Талархал”, дурсгалын зүйлээр тус тус урамшуулав.

**-Цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт хамрагдаж байгаа болон бие даан хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хугацаа, үр дүнгийн талаар тусгах:**

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын 29 заалттай салбар төлөвлөгөө гарган 2018 оны эхний хагас жилийн байдлаар 44.4 хувьтай хэрэгжиж төлөвлөгөөний биелэлтийг холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

“Эрүүл ирээдүй” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрх зүйн мэдээ, мэдээллийг төрийн алба хаагч, иргэдэд хүртээмжтэй цогцоор нь хүргэх зорилгоор Аймгийн ЗДТГ, Хууль эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Шүүх, Прокурорын газар, Татварын хэлтэс, Аудит, Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, ШШГА, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Биеийн тамир спортын газар зэрэг байгууллагын эрх зүйн сургалтын хамтарсан баг “Иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээ” сэдэвт хууль сурталчлах арга хэмжээг нийт 16 сум, 1 тосгоны 875 иргэнийг хамруулан 2018.06.04-ний өдрөөс 06.11-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгууллаа. Цагдаагийн газраас иргэдэд Цагдаагийн байгууллагын

бүтэц, чиг үүрэг, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар тус тус мэдээ, мэдээлэл өгч, саналын хуудсаар саналыг авч ажиллалаа.

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/120 дугаар тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд нэмэлт төлөвлөгөө гарган баг, хамт олныг нэгтгэх, түүхэн уламжлал, туршлагаас суралцахад чиглэсэн олон талт соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах 36 заалттай төлөвлөгөө гарган, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 41.5 хувьтай хэрэгжиж төлөвлөгөөний биелэлтийг холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын баталсан “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хүрээнд Цагдаагийн газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн Б/62 дугаар тушаалаар тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг томилж, 21 заалт бүхий салбар төлөвлөгөө гарган үр дүнг тооцон ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/127 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 22 заалттай төлөвлөгөө гарган 2018 оны эхний хагас жилийн байдлаар 45.0 хувьтай хэрэгжиж холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

### **-Тайлангийн хугацаанд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээг тусгах:**

Цагдаагийн Ерөнхий газрын 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 46/658 албан бичгээр ирүүлсэн “Цагдаагийн байгууллагын авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө”, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хүлээн авч, 120 алба хаагчид танилцуулан “Цагдаагийн газрын 2018 оны авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 18 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан Цагдаагийн газрын даргаар батлуулан тасаг, албадад хүргүүлэн биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Цагдаагийн газрын нийт алба хаагчдад “Авлига, ашиг сонирхлын тухай ойлголт”, “Авлигын эсрэг хууль, тогтоомжийн тухай ойлголт” сэдвээр 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдөр 1 цагийн сургалт орж, 96 алба хаагчаас тест боловсруулан шалгалт авахад 62 алба хаагч 80-100, 29 алба хаагч 70-80, 5 алба хаагч 60-70 хувьтай дүгнэгдсэн.

Мөн авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд алба хаагчдын дунд “АХА” тэмцээнийг зохион байгуулж үр дүнг тооцож 3 алба хаагчийг урамшуулан ажилласан.

Цагдаагийн газрын 94333102 тоот дугаарын утсанд 24 цагаар Цагдаагийн алба хаагчийн авлига, ашиг сонирхлын зөрчил, хууль бус үйлдлийн талаар мэдээлэл авч ажиллаж байгаа талаар 80 ширхэг зурагт хуудас хэвлүүлж аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 20 төрийн болон төрийн бус байгууллагад тараан ажилласан бөгөөд авлига, эдийн засгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлж, таслан зогсоох ажилд хүн бүрийн оролцоо чухал зурагт хуудсыг хэвлүүлэн аймгийн хэмжээнд нийт 460 ширхэгийг тараан ажилласан байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудаар тухай бүр нь Цагдаагийн газрын нийт алба хаагчдад долоо хоногийн мягмар гариг бүр сургалтыг орсоноос гадна тус Цагдаагийн газрын эдийн засгийн ахлах мөрдөгч авлига, албан тушаалын эсрэг гэмт хэргийн нийгмийн хор аюул, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар Цагдаагийн газрын нийт 120 алба хаагчдад Цагдаагийн газрын 1-р улирлын сахилга хариуцлагын зөвлөгөөний үеэр сургалт орж мэдлэг эзэмшүүлсэн байна.

Цагдаагийн газрын нийт алба хаагчдад авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих алба хаагчдын сэтгэл зүйг төлөвшүүлэх зорилгоор авлигаас ангид байх амлалтын дэвтэрийг аялуулж сэтгэл зүйг төлөвшүүлэх зорилгоор Цагдаагийн газрын хүний сэтгэл зүйчээр “Хуулийн байгууллагын ажилтны сэтгэл зүй” сэдвээр цагдаагийн газрын алба хаагчдад

сургалт орж, орсон сэдвээрээ 10 асуулт бүхий тестийг боловсруулж шалгалт авж үр дүнтэй тооцсон байна.

Авлигаас урьдчилан ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Цагдаагийн газраас Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа бүтээцгээе сургалтыг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 8 төрийн байгууллагад сургалтыг орж ажилласан байна.

Шинэчлэн батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн тухай ойлголт, анхаарах асуудал сэдвээр цагдаагийн газрын нийт алба хаагч нарт сургалтыг орж авлига, албан тушаалын гэмт хэрэгт өртөхгүй мөн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар Цагдаагийн газрын нийт алба хаагч нараас баталгаа гаргуулан гарын үсэг зуруулан авсан байна.

2017 оны 12-р сарын 25-ны өдөр ЦБҮАЖ-д шинээр орсон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, код 139-д заасан Авлигаас урьдчилан сэргийлэх Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, 140-д заасан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой заалтуудаар сургалт орсон байна.

Мөн 2018 оны 1-р улирлын сахилга хариуцлагын зөвлөгөөний үеэр алба хаагч бүр авлигын сэжигтэй тохиолдол болон авлига өгөхөөр оролдсон, санал болгосон тохиолдол бүрт холбогдох албан тушаалтан, байгууллагад заавал мэдээлдэг байх, иргэдээс авлига өгөхийг санал болгосон, өгөхөөр завдсан тухай удирдах албан тушаалтандаа илтгэх ёстой талаар итгэл үнэмшлийг бий болгох зорилгоор “Шударга, нийгэм-Шударга алба хаагч” нэртэй сургалтыг орж нийт 116 алба хаагчаас баталгаа авч гарын үсэг зуруулан авсан байна.

#### **-Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар тусгах:**

2018 оны эхний хагас жилийн байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас цагдаагийн байгууллагад иргэд, байгууллага аж ахуйн нэгж, албан тушаалтнаас ирүүлсэн өргөдөл гомдол мэдээлэл хугацаатай үүрэг чиглэл өгч ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 6 өргөдөл, гомдол иржээ. Нэр бүхий 6 иргэнд ирүүлсэн гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаар хариуг хүргүүлэн ажилласан.

#### **-Алба хаагчдын сахилга, хариуцлага ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ тусгах:**

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 03-р сарын 26-ны өдрийн А/92 дугаар тушаалын дагуу тус газраас “Хариуцлага, сахилгыг дээшлүүлье” 1 сарын аяныг 2018 оны 05-р сарын 28-ны өдрөөс 2018 оны 06-р сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулахаар 8 заалт бүхий төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулан ажилласан.

Аяны хүрээнд Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш сурган хүмүүжүүлэх ухааны доктор, Монголын эмэгтэй эрдэмтдийн холбооны Орхон аймаг дахь салбарын тэргүүн, Монголын эмэгтэй эрдэмтдийн холбооны нарийн бичгийн дарга Б.Энхцэцэгийг урьж “Харилцаа, өөрийгөө илэрхийлэх чадвар” сэдэвт 2 цагийн сургалтанд 104 алба хаагч, Орхон аймгийн Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш н.Алтанцэцэгийг урьж “Харилцааны соёл” сэдэвт 3 цагийн сургалтанд 110 алба хаагчид тус тус хамрагдсан.

Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсийн даргын 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 36/1559 тоот албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу 2018 оны 01 дүгээр улирлын “Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдөр шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, алба хаагчдын санал хүсэлтийг сонсож, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцэж ажилласан.

Аймгийн төвд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний гарч Булган аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/101 тоот захирамжаар хорио



цээрийн дэглэм тогтоосон бөгөөд сумдын алба хаагч нарыг оролцуулах боломжгүй байсан тул төвийн 47 алба хаагчдад сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсийн даргын 2018 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 36/1625 тоот албан бичгээр ирүүлсэн Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын 2017 оны сахилга, ёс зүйн байдалд дүн шинжилгээ хийсэн мэдээллийг “Power point” программ дээр бэлтгэж, төвийн 47 алба хаагчдад мэдээлэл өгч, нийт сумдад мэдээллийг цахимаар хүргүүлж ажилласан.

Мөн 2018 оны 01 дүгээр улирлын Сахилга хариуцлагын зөвлөгөөнийг “Power point” программ дээр бэлтгэн сахилгын зөрчил гаргасан 7 алба хаагчдын шалтгаан нөхцлийг алба хаагч нарт танилцуулж цаашид дахин зөрчил дутагдал гаргахгүй байх талаар хамт олноороо хэлэлцэн ажилласан.

2018 оны 01 дүгээр улиралд зохион байгуулсан Сахилга хариуцлагын зөвлөгөөнөөс “Сахилга ёс зүйн зөвлөл”-ийг шинэчлэн батлах тухай шийдвэрийг гаргасан.

2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн Цагдаагийн газрын даргын А/18 дүгээр тушаалаар Сахилга ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн 9 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулж байна.

Цагдаагийн газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/31 дугаар тушаалаар сахилга, ёс зүйн албаны журмыг шинэчлэн батлан сахилгын ёс зүйн албаны журмыг тушаалын нэгдүгээр, сахилга ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчтай байгуулах гэрээг тушаалын хоёрдугаар, амаар өгсөн зөвлөгөө, зааварчлага, баталгааны хуудсны загварыг тушаалын гуравдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсан нь шинэлэг ажлын эхлэл болсон.

Сахилга ёс зүйн зөрчил гаргасан 7 алба хаагчид “Сахилга ёс зүйн албаны журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж, дахин сахилга ёс зүйн зөрчил гаргахгүй байх гэрээ байгуулж, биечлэн зөвлөгөө зааварчилга өгч бичгээр баталгаажуулах, баталгааны хуудас өөрөөр нь бичүүлэн авч ухамсарлуулах үйл ажиллагаа явуулан ажилласан.

Энэхүү арга хэмжээ нь сахилга ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчид итгэл өвөрлөж, үүрэг хүлээсэн ажил болсон.

2018 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн Сахилга ёс зүйн зөвлөлийн хурлаас зөрчил гаргасан алба хаагч нартай сэтгэл зүйч фокус ярилцлага зохион байгуулах, сахилга ёс зүйн зөвлөлийн гишүүн бүр алба хаагчийн сахилга хариуцлагын байдалд нөлөөлөхүйц сургалтууд орох шийдвэрийг гарган ажиллаж байна.

Мөн 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс 2018 оны 06 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл “Ёс зүйтэй хамт олон” шалгаруулах удирдамж боловсруулан тасгийн дарга нарт хүргүүлэн шалгарсан алба хаагчдыг урамшуулсан

2018 оны эхний хагас жилийн байдлаар 7 алба хаагч сахилгын арга хэмжээ авагдсан байна. Үүнээс сануулах 4 алба хаагч, албан тушаалын үндсэн цалин хасах 2 алба хаагч, албанаас халах 1 алба хаагч арга хэмжээ авагдсан нь урьд оны мөн үеэс 6.6 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

### **-Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр товч тусгах:**

Тус газар нь 2018 оны эхний хагас жилийн байдлаар 912674.3 мянган төгрөгийн төсөвтэй 3000,0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллаж, гүйцэтгэлээр 912674.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3139.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөө бүрэн биелсэн, нэмэлт санхүүжилтээр нийт 70519,5 мянган төгрөгийн санхүүжилт авч гэмт хэргийн дуудлагын фургон автомашин худалдан авах, 2017 он, 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны эмхтгэл бэлтгэх, мэдүүлэг авах өрөөний засвар, малын гоц халдварт шүлхий өвчний хорио цээрийн үеийн хамгаалалт болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулж ажилласан байна.

Төсвийн санхүүжилт, зардлын гүйцэтгэлийн задаргааг хүснэгтээр авч үзвэл: /мян төг/

ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ, ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	0	0	0	0
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	915674300	883059956	32614344	96.4
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	915674300	883059956	32614344	96.4
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ, ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	915674300	883059956	32614344	96.4
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	739085400	723082154	16003246	97.8
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	485787000	472953186	12833814	97.4
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	253298400	250128968	3169432	98.7
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	16382400	16124043	258357	98.4
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	2855100	2721443	133657	95.3
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	13527300	13402600	124700	99.1
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	67848600	58853364	8995236	86.7
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	55017000	54899703	117297	99.8
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	7578800	7517042	61758	99.2
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	13510200	12423550	1086650	92.0
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	9139800	9101500	38300	99.6
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	1	1	-	
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	136	128	8	
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	1	1	-	
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	132	123	9	
ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ ᠮᠤᠨᠤᠯᠤᠰᠤ	3	4	-1	

Төсвийн зардлыг бүлгээр нь авч үзвэл: Нийт зардлын 81,8 хувийг цалин, 6,7 хувийг тогтмол зардал болох халаалт, цэвэр бохир ус, цахилгааны зардал, 6,2 хувийг хангамж бараа материалын зардал, 0,85 хувийг нормативт зардал, 1,03 хувийг дотоод албан томилолтын зардал эзэлж байна. Дээрх хүснэгтийн тоон мэдээллээс зардлын гүйцэтгэл нь үлдэгдэлтэй харагдаж байгаа нь тухайн сарын ажил гүйлгээний гүйцэтгэлээр зарлага хийгддэг тул зарим ажил гүйлгээний гүйцэтгэл бүрэн хийгдээгүй байгаа үзүүлэлт болно.

Цалингийн зардлыг төсөвтөө багтаан сар бүр алба хаагчдын ажлыг дүгнэн үр дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэдэг бөгөөд 2018 оны 2-р улирлын байдлаар ажлын үр дүнгээр нь давхардсан тоогоор 37 алба хаагчийн цалинг 5-20 хувиар нэмж 15435,3 мянган төгрөг, 53 алба хаагчийн цалинг 5-20 хувиар хасаж 7900,7 мянган төгрөг, 2 алба хаагчийн цалинг 3 сар хүртэл 20 хувийн сахилгын арга хэмжээг цалингийн сангаас тооцон олгосон. Эхний улирлаар 8 орон тооны дутуу, цалингийн хэмнэлттэй үзүүлэлттэй бүрэн орон тоогоор ажиллавал цалингийн сан хүрэхгүй байх тооцоо гарч байна.

Тайлант хугацаанд 2 иргэнд галт зэвсгийн гэрчилгээ шинээр олгож, торгууль торгох эрх бүхий 67 алба хаагч нарт 21 шийтгэлийн маягт-1, шийтгэлийн маягт-2 тасалбар шинээр нэмэж олгон 1933,5 мянган төгрөгийн торгуулийн орлогыг бэлнээр, 19597,3 мянган төгрөгийн бэлэн бус орлогыг сум, орон нутгийн хүү торгуулийн дансанд оруулсан байна.

Монгол Улсын Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын "Журам шинэчлэн батлах тухай" 2016 оны 29 дүгээр тогтоол, мөн "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай" 2009 оны 143 дугаар тогтоол, ЦЕГ-ын даргын 2014 оны 911 дүгээр тушаалаар баталсан "Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /код 135/ журмын хэрэгжилтийг ханган "Шилэн данс"-ны цахим хуудсанд бүртгүүлэн нэвтрэх эрх авч, журмын дагуу цаг хугацаанд нь холбогдолтой мэдээллүүдийг бүрэн оруулж хэвшээд байна.

Шилэн дансны тухай Монгол улсын хуулийн хэрэгжилтийг хангаж Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны "Төсөв гүйцэтгэл", "Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт", "Бусад" гэсэн 3 дэд цэсэнд тухай бүр, сар бүр, улирал, хагас, бүтэн жилээр тус бүр оруулах хугацаагаар ангилан уг хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан хуулийн 6 дугаар зүйлд заасан шилэн дансны мэдээллийг тогтмол оруулна гэсний дагуу "Шилэн данс"-ны цахим сүлжээнд 2018 оны эхний хагас жилийн байдлаар тухай бүрд оруулах 8 мэдээлэл, сар бүр оруулах 2 мэдээлэл, улирал бүр оруулах 1 мэдээллийг цаг тухай бүрд нь оруулж мэдээллийг баяжуулан бүртгэсэн байна.

Тухайн мэдээллийг оруулахдаа тухай бүрд нь үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх, мэдээлэл ойлгомжтой байх, хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх гэсэн шилэн дансны зарчмыг хангаж ажилласан.

Аудитын чиглэлээр 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлэгдсэн гэж дүгнэсэн.

Мөн менежментийн захидалдаа тухайн сарын төсөв хүрэлцэхгүйгээс бүлэг хооронд зардлыг шилжүүлэн зарцуулсан нь санхүүгийн тайланд материаллаг хэмжээгээр нөлөөлөх 4 зөвлөмжийг хүлээн авч, биелэлтийг 6 сарын 30-ны дотор гаргаж албан тоотоор хүргүүлэн шилэн дансны мэдээлэлд 7 сарын 01-ний дотор байршуулан мэдээлсэн.

### **-Тайлангийн хугацаанд зохион байгуулсан, шинэлэг ажил, арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар тусгах:**

Булган суманд малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдож хорио цээрийн постонд 5 ширхэг туузан гэрэл /Маяк/ БНХАУ-ын Эрээн хотоос худалдан авч суурь хийж постуудад байршуулан нь эрсдлээс урьдчилан сэргийлэх шинэлэг ажил болсон.

Нарны энеригээр цэнэглэгддэг суурин туузан гэрэл /маяк/-нд хөл гагнаж, ажиллагааг шалгаж Зоон даваа, Хөх монгол, Шунхлай уулзвар, Хужир толгой, 18-ын дөрөлж зэрэг 5 постонд байрлуулж ажиллалаа.

Хогийн жалга, Өлийн даваа, Дашмэргэний пост зэрэг 3 постонд байрлуулж нарны элементыг нар руу харуулж цэнэглэхэд тохиромжтойгоор суурийг эргүүлдэг байдлаар хийж гүйцэтгэсэн.

Албан үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдсэн Д.Даарий агсаны Цагдаагийн газрын хашаанд байх дурсгалын хөшөөт цогцолборыг шинэчилэн засварлах ажлын хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Дурсгалын хөшөө рүү очих явган хүний замыг шинэчилэн засварласан.

Дурсгалын хөшөөний талбайг томруулж, ЭКО хавтангаар шинэчилэн засварлаж дөрвөн буланд шинээр гэрэлтүүлэг суурилуулж, дурсгалын хөшөөг доороос нь гэрэлтүүлэх гэрэл суурилуулсан.

Уг талбайд гантигаар өнгөлсөн суурь хийж “Цагаан шонхор” билэгдэлийг байрлуулсан.

Д.Даарий агсаны дурсгалын хөшөөг засварлах ажилд 3,5 сая төгрөгийг төсөвлөн одоогоор зарцуулаад байна.

### -Бусад -

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/64 дүгээр тушаалаар Булган аймаг дахь Цагдаагийн газрын түүхт 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай зөвшөөрөл олгогдож, байгууллагын түүхэн уламжлалыг сурталчлах, бүтээлч ажил өрнүүлэх, хамт олны сахилга ёс зүй, ажлын идэвхи санаачилгыг дээшлүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил, арга хэмжээ зохион байгуулж, явц, үр дүн, санхүүжилтийн эх үүсвэрийг тухай бүр нь танилцуулж ажилласан.

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын А/64 дугаар тушаалыг үндэслэн тус Цагдаагийн газрын даргын Б/49 дугаар тушаал гарган Аймгийн Иргэдийн хурлын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга М.Оюунбатад албан бичгээр ой тэмдэглэн өнгөрүүлэх зөвшөөрлийг олгох тухай хүсэлтийг хүргүүлэн 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн Иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдаанаар орон нутагт тус Цагдаагийн газрыг 80-н жилийн ойг 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэх тухай Тэргүүлэгчдийн тогтоолыг гаргуулсан.

Булган аймаг дахь Цагдаагийн газрын түүхт 80-н жилийн ойн хүрээнд зохион байгуулах “Булган цагдаа-80 бүтээлч ажил” аяны хэрэгжүүлэх ажлын 6 чиглэл, 80 заалттай төлөвлөгөөг боловсруулан Цагдаагийн газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Цагдаагийн газрын түүхт 80 жилийн ойн хүрээнд зохион байгуулах ажлын хэсгийг томилон ажлын үр дүнг тухай бүр нь тооцон ажиллаж байна.

Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, Булган аймгуудад тус Цагдаагийн газарт ажиллаж байсан үе үеийн ахмад ажилтан, алба хаагч нарын уулзалт өдөрлөгийг зохион байгуулан ая дууны мэндчилгээ хүргэн түүхт 80-н жилийн ойн арга хэмжээг сурталчилан тус газрын цахим хуудсанд байршуулан ажилласан.

Цагдаагийн газрын 80-н жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан дурсгалын энгэрийн тэмдэг, лого /медальон/-ы уралдааныг нээлттэй зарлаж Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч Б.Батбаярын санаачилан загвар гаргасан дурсгалын энгэрийн тэмдэг, Замын цагдаагийн тасгийн зохицуулагч, цагдаагийн дэслэгч Өнөрбатын лого /медальон/-нь шалгарсанаар 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдөр 34/01-761 дугаартай албан бичгийг Цагдаагийн Ерөнхий Газрын даргад танилцуулан зөвшөөрөл авсан.

Булган аймгийн Цагдаагийн газрын түүхт 80-н жилийн ойн шүлэг, ая, дуу зохиох уралдааныг зарлан “Монгол цагдаа” дууны үг ая шалгарч Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын дуучин Монгол улсын гавъяат жүжигчин Б.Батбаатар дуулахаар болсон.

Булган аймгийн Цагдаагийн газрын түүхт 80 жилийн ойд зориулан түүхэндээ анх удаа “Анхдагч алдартны өлгий Булганы цагдаагийн түүхэн товчоо” номын эхийг бэлтгэн хэвлэлтэнд өгсөн.

Ард түмнийхээ энхийн манаанд өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэн удаа дараа онц ноцтой гэмт хэрэг үйлдэж хорих байгууллагаас оргон зайлсан онц аюултай гэмт этгээдүүдийг эрэн сурвалжилан баривчлах үедээ алтан амиа алдсан ахлагч Д.Даарий агсаны дурсгалын хөшөөний орчныг шинэчлэн засварлах, “Цагаан шонхор” хөшөөг босгох ажлыг эхлүүлэн түүний ар гэр, үр хүүхэдүүдтэй уулзалт зохион байгуулсан.

2018 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Цагдаагийн газрын алба хаагчдын “**Гэр бүлийн уулзалт**”-ыг зохион байгуулан Цагдаагийн газрын дарга арга хэмжээг нээж үг хэлж, Захиргааны удирдлагын тасгийн дарга ой угтаж зохион байгуулж байгаа бүтээн байгуулалт, цаашид хэрэгжүүлэх ажлаа тайлагнаж, Ахмадын зөвлөлийн дарга, “Цагдаагийн гурван үеийн хэлхээ” төрийн бус байгууллагын тэргүүн, цагдаагийн бэлтгэл хошууч Д.Шийрав гуайн гэр бүл Ё.Пагамсүрэнг урьж дурсамжит яриа өрнүүлэн, түүний амьдралын туршлага, цагдаагийн гэр бүл ямар байх тухай сонирхолтой яриаг өрнүүлэн,

алба хаагчдын гэр бүлээс санал, хүсэлтийн сонсож нэгтгэн хариулт өгч ажилласан нь тэдний итгэл, урам зоригийг сэргээсэн арга хэмжээ болсон.

2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Цагдаагийн газрын алба хаагчдын дунд “Урлагын бага наадам” зохион байгуулан уригдан ирсэн гэр бүл, түүний гишүүд үзэж, шүүгчийн үнэлгээгээр Нийтийн хэв журам хамгаалах тасаг 1 дүгээр байр, Рашаант суман дахь сум дундын цагдаагийн тасаг 2 дугаар байр, Хангал суман дахь сум дундын цагдаагийн тасаг 3 дугаар байрыг тус тус эзэлсэн нь алба хаагчдын урмыг сэргээсэн соён гэгээрүүлэх арга хэмжээ болсон. Цагдаагийн газрын түүхт 80-н жилийн ойн концертыг зохион байгуулахад оролцох алба хаагчдыг сонгон шалгаруулж, Дархан-Уул аймгийн Залуучууд театрын ерөнхий найруулагч Г.Саранчимэгийг урьж 25 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй 15 номертой урлагын тоглолтыг бэлэн болгосон.

2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн Аймгийн Иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдаанд тус газрын 80 жилийн түүхэн замнал, гавъяа, хөдөлмөр, үр бүтээлийг үндэслэн “Цэргийн гавъяа”-ны одонгоор шагнуулах тодорхойлолтыг Цагдаагийн газрын Ахмадын зөвлөлөөс оруулан тэргүүлэгчдээр хэлэлцүүлсэнээр дэмжигдэн Тэргүүлэгчдийн хурлын тогтоол гарч Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн.

2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн Аймгийн Иргэдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар Цагдаагийн газрын өргөтгөл, гадна фасатыг шинэчлэх 156,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэхээр зураг, төсвийг танилцуулсан нь дэмжигдэж ойг тэмдэглэн өнгөрүүлэх тогтоолын 3 дугаар заалт болгон оруулж, хөрөнгийн эх үүсвэрийг 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэсд оруулан төсвийн тодотголоор хэлэлцэн боловч одоогоор эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

Цагдаагийн газрын Сургалт, дадлагын төвийг өргөтгөх ажлын хүрээнд дотоод нөөц бололцоондоо тулгуурлан 1 байр /Шовгор/ нэмж барих, хашааг шинэчлэх ажлыг эхлүүлсэн.

Булган аймгийн Ерөнхий прокурор, Цагдаагийн газрын даргын хамтарсан 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01, А/09 дугаар тушаалаар 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хооронд зохион байгуулж буй “**Булган цагдаа бүтээлч ажил-80**” аяны хүрээнд Монгол Улсын Их Хурлаас шинэчлэгдэн батлагдсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, “Мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар”-ыг нэг мөр хэрэгжүүлэн, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэлтийн болон мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж буй хэргийг үндсэн хугацаанд нь шуурхай шалгаж шийдвэрлэх, хэргийн эцсийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, гэмт хэргийн шинжгүй үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэг хэрэгсэхгүй болгох, хэргийн хугацаа сунгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчил гаргах явдлыг таслан зогсоож, мөрдөн шалгах ажиллагаа түүнд тавих хяналтын ажлын чанар, үр дүнг сайжруулах ажлыг зохион байгуулан биелэлт, үр дүнг тооцон ажиллаж байна.

“Булганы цагдаа-Бүтээлч ажил 80” аяны хүрээнд конторын барилгын В-1 давхарт өрөө тохижуулан “**Цахим номын сан**” байгуулах ажлыг Иргэний зөвлөлийн гишүүдтэй хамтран зохион байгуулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Аймгийн иргэний зөвлөлийн гишүүдээс 50 ном тус Цагдаагийн газарт хандивласан.

Булган аймаг дахь Цагдаагийн газрын түүхт 80 жилийн ойг тохиолдуулан “**Булган цагдаа-80 бүтээлч ажил**” **цахим хуудас** нээж үе үеийн ахмадууд, тус газарт ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа алба хаагч нарын санал, хүсэлтийг хүлээн авч хэрэгжүүлэх шинэлэг санал, санаачлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дээрхи арга хэмжээнүүдийг Булган аймаг дахь “Сайхан монгол” телевиз, “Шинэ мэдээ” сонин, Орхон аймаг дахь Номин телевиз, Булган цагдаагийн газар “PAGE” хуудас, BULGAN.POLICE.GOV.MN веб хуудаст тогтмол байршуулан үйл ажиллагаагаа сурталчилан ажиллаж байна.

**Хоёр.Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ**

Нэг. Өргөдөл гомдол, мэдээллийн талаар:

Тус цагдаагийн газарт иргэд байгууллага, албан тушаалтанаас 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 786 гомдол мэдээлэл хүлээн авсан нь өнгөрсөн оны мөн үеэс 464 гомдол мэдээлэл буюу 37,2 хувиар буурсан байна.

Хүлээн авсан нийт гомдол мэдээллийн 210 буюу 26,7 хувь нь гэмт хэргийн шинжтэй өргөдөл гомдол мэдээлэл байгаа ба үүнээс 176 буюу 83,8 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 34 буюу 16,1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байна. Зөрчлийн шинжтэй нийт 576 гомдол мэдээлэл бүртгэгдсэнээс 437 буюу 75,8 хувийг зөрчлийн хэрэг нээж буюу хялбаршуулсан журмаар, 75 буюу 13,1 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн.

Нийт гомдол мэдээллээс хүний амь бие эрүүл мэндийн эсрэг 19, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 34, өмчлэх эрхийн эсрэг 71, мал хулгайлах 11, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг 295, хүрээлэн байгаа орчны эсрэг 12, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 43 бусад 301 гомдол бүртгэгдсэн байна.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинээр Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай багц хуулиуд хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг 5 хоногийн хугацаанд, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийг ажлын 3 хоногийн хугацаанд шалгаж шийдвэрлэхээр тусгасан зэрэг өргөдөл гомдол шалгаж шийдвэрлэхтэй холбоотой хуулийн хэрэгжилтийг нэг мөр хангаж ажиллах талаар нийт гэмт хэрэг зөрчил шалгах эрх бүхий алба хаагчдад Прокурорын газартай хамтарсан сургалтыг зохион байгуулсан.


Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч бүртгэн, цагдаагийн газрын удирдлагад танилцуулж, гомдол, мэдээллийн шийдвэрлэлт, явцын талаар 7 хоног тутам газрын удирдлага, алба хаагчдад мэдээлэл хийж, шийдвэрлэлт нь удааширч байгаа гомдол, мэдээлэл нэг бүрийг танилцуулж ажиллаж байна. Прокурорын газрын туслах тоо бүртгэл хариуцсан ажилтантай 7 хоног бүрийн Баасан гарагт гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн тулгалтыг хийж ажлын өдрүүдэд мэдээллийн нэгдсэн санд орсон мэдээлэл нэг бүрийг Цагаагийн газар Прокурорын газрын нэгдсэн бүртгэлд бүртгэж ажилласан.

ЦЕГ-с хэрэгжүүлж байгаа мэдээлэл холбоо технологийн бодлогын хүрээнд иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдол мэдээлэл бүрийг мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлж байгаатай холбогдуулан алба хаагчдын өргөдөл гомдол мэдээллийг шийдвэрлэж буй байдалд онлайн хэлбэрээр хяналт тавьж ажиллаж байна.

#### Хоёр. Гэмт хэргийн талаар:

Аймгийн хэмжээнд 2018 оны эхний 6 сарын байдлаар 142 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4 хэргээр буюу 2.7 хувиар буурсан.

БҮСТЗЭТХэрэг 126 бүртгэгдэн 61 хэргийг илрүүлж, гэмт хэргийн илрүүлэлт 48,4 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 21,2 хувиар буурсан.





- Гэмт хэргийн улмаас 51 хүн гэмтсэн нь ХЭМХБЭГХ-ийн улмаас 45, ХАБТХАЖЭГХ-ийн улмаас 4 хүн, бусад хэргийн улмаас 2 хүн гэмтсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 30 хувиар буурсан.

#### СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙД

- Сogтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 17 бүртгэгдэж 25 хэргээр буюу 59,5 хувиар буурсан.

#### БҮЛГЭЭР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙД

- Нийт 15 хэргийг бүлгээр үйлдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 3 хэргээр буюу 25 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

#### ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГСДИЙН ТАЛААР

- 61 гэмт хэрэгт 93 хүн холбогдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 72 хүнээр буюу 44,1 хувиар буурсан.

Зөрчил гаргасан нийт 5931 зөрчилд 239,1 сая төгрөгний торгуулийн арга хэмжээ авсан байна.

- ❖ Гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 246 хүн эрүүлжүүлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 91 хүнээр буюу 27 хувиар буурсан байна.
- ❖ Захиргааны журмаар 75 хүнийг баривчилж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж, торгуулсан 103 иргэн байна.

#### **-Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:**

Эрүүгийн цагдаагийн газрын 2017 оны “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 02 тоот албан даалгаварын хүрээнд 2018 оны эхний хагас жилийн байдлаар уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх зорилгоор салбар төлөвлөгөө боловсруулан цагдаагийн газрын даргаар батлуулан сумдын тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарт урьдчилан сэргийлэх зурагт хуудасны хамтаар хүргүүлж ажиллалаа. Мөн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг шат дарааллан хэрэгжүүлж аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг цахим тоглоомын газрууд, интернет кафе, уг гэмт хэргийг үйлдэж болзошгүй өсвөр насны хүүхдүүд, байгууллага аж ахуй нэгжийн IT инженерүүдийг аймгийн Тагнуулын хэлтэстэй хамтран хяналтанд авч ажиллаж байна.

Эрүүгийн цагдаагийн газрын даргын 2016 оны “Хар тамхи мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 02 тоот албан даалгаварын хүрээнд салбар төлөвлөгөө боловсруулан цагдаагийн газрын даргаар батлуулан ажиллаж, Булган аймаг дахь ГХУСАЗЗөвлөлөөр нэмэлт хөрөнгө шийдүүлэн 2018 оны 04, 05 дугаар саруудад аймгийн Байгаль орчны газар, Тагнуулын хэлтэстэй хамтран устгалын ажиллагааг зохион байгуулан ажилласан.

Мөрдөн байцаах газрын 2016 оны 01 тоот албан даалгаварын хүрээнд 2018 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган аймгийн Тагнуулын хэлтэс, Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран ажиллах гэрээ байгуулж уг гэрээнд тусгагдсан ажлын дагуу аймгийн хэмжээнд тэсэрч дэлбэрэх бодис ашиглан үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдэд 2018 оны 08 дугаар сард нэгдсэн хяналт шалгалтыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх тэр дундаа хууль бус мод



бэлтгэлийн ажиллагааг таслан зогсоох зорилгоор аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран 2018 оны 02 дугаар сард эргүүл шалгалтыг зохион байгуулж ажиллалаа. Тайлангийн хугацаанд тус тасгийн алба хаагчид нийт 152 мэдээ мэдээлэл илтгэх хуудас авч баримтжуулан шалгаж ажилласан. Эрүүгийн цагдаагийн тасаг нь эрэн сурвалжлах “АСАП” сангийн ашиглалтын чиглэлээр өөрийн хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулахдаа УИХ-ын 2017 оны 02 сарын 09-ны өдөр шинэчлэн батлагдаж 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдөр дагаж мөрдөгдсөн “Цагдаагийн албаны тухай хууль”, Гүйцэтгэх ажлын заавар, ЦЕГ-ын даргын 2015 оны 06 сарын 19-ны өдрийн 44 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулан баталсан “Эрэн сурвалжлах ажлын журам” Код-229 болон бусад хууль эрхийн актыг удирдлага болгон ажиллалаа. Эрэн сурвалжлах ажил, “ASAP” сан хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч 1 ажиллаж ASAP сангаар улсын хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа сураггүй алга болсон хүн, хулгайд алдсан эд зүйл, тээврийн хэрэгсэл, галт зэвсэг, хэн болох нь тогтоогдоогүй цогцос, ХБ, МБ, Прокурор, Шүүх, хорих ангиас оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг орон нутагт эрэн сурвалжлах зорилгоор алба хаагчдад тогтмол зарлан мэдээлж хэсгийн байцаагч нарт тараан хүн олноор цуглардаг дэлгүүрийн мэдээллийн самбарт байрлуулж, Булган аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдээд оргон зайлсан сэжигтэн яллагдагч, шүүгдэгч, гэмт хэргийн замаар алдагдсан мал, эд зүйлийг эрэн сурвалжлах зорилгоор “**БУА эрэн сурвалжаж**”, “ASAP” сангаар улсын хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал, эд зүйл, тээврийн хэрэгсэлийн мэдээллийг “**АСАП эрэн сурвалжлах**” хаалттай facebook group-ийг ашиглан алба хаагчдад мэдээллийг цаг алдалгүй хүргэж байна. Эрэн сурвалжлалт хариуцсан ахлах мөрдөгч нь ЦЕГ-ын мэдээллийн сүлжээ эрэн сурвалжлах “ASAP” санд эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал, эд зүйлийн мэдээллийг тогтмол оруулж бусад алба хаагчдаас оруулсан мэдээллийг тухай бүр хянаж, бүртгэж ажилласан байна. Тайлангийн хугацаанд төв, орон нутгийн цагдаагийн газар хэлтсээс “ASAP” сангаар улсын хэмжээнд эрэн сурвалжилсан нийт 29 эрэн сурвалжлах зарлан мэдээллийг зурган хэлбэрээр “Facebook” group-т оруулан алба хаагчдад танилцуулан ажилласан бөгөөд алба хаагч нар тухайн зарлан мэдээлэлтэй 81 хувьтай танилцаж, танилцсан талаараа comment үлдээж хэвшсэн байна. “Facebook group”-т байршуулсан мэдээллийн тоо харьцангуй бага байгаа нь өнгөрсөн 3,4 дүгээр саруудад Булган аймгийн Булган, Рашаант, Сайхан, Хишиг-Өндөр, Бугат сумдад малын гоц халдварт Шүлхий өвчин гарч хорио цээрийн дэглэмд цагдаагийн газраас алба хаагчид 2 сарын хугацаанд ажилласан, Камерын хяналтын төвд үүрэг гүйцэтгэх оператор цагдаагийн орон тоо хангалтгүйгээс өдрийн 1 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна. Зарим тохиолдолд жижүүрийн офицер камерын хяналтын төвд давхар ажиллаж байгаа байдлууд нөлөөлсөн байна.

2018 оны эхний хагас жилийн байдлаар Булган аймгийн Цагдаагийн газраас ASAP сангаар гэмт хэрэгт сэрдэгдсэн болон ХБ, МБ, прокурор, шүүхээс оргон зайлсан 9 этгээдийг эрэн сурвалжлан ажилласнаас 7 этгээдийг дайчлан ажиллаж одоо этгээдийг үргэлжлүүлэн эрэн сурвалжилж байна.

2018 оны 5 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд оршин суух газраасаа сураггүй алга болсон хүн төлөвт “АСАП” сангаар эрэн сурвалжлагдаж байсан Булган аймгийн Булган сумын харьяат насанд хүрээгүй Олдохгүйсайхан овогтой Мөнгөнцэцэг гэгчийг Улаанбаатар хотод эрэн сурвалжлах ажиллагааг шуурхай зохион байгуулан олж тогтоон ажилласан.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хоёрдугаар хэлтсээс эрэн сурвалжлалт зарлагдсан бага насны хүүхэд болох Д.Сувданцэцэг гэгч нь Булган аймгийн Булган суманд байна гэх мэдээллийг дагуу тус цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгийн мөрдөгч нар эрэн сурвалжлах ажлыг шуурхай зохион байгуулан ажиллаж Булган аймгийн Булган сумын 1 дүгээр багийн нутаг Шинэ хороо задгайд оршин суух эрхэлсэн тодорхой ажилгүй “Э” гэгчийнд байхыг олж тогтоон улмаар Д.Сувданцэцэгийг ар гэрийн хүмүүст нь хүлээлгэн өгч ажилласан байна.

2017 оны 12 дугаар сарын 06-ны орой Булган аймгийн Тэшиг сумын харьяат Дагвадорж овогтой Ганзориг гэгч нь Сэлэнгэ сумын төвд оршин суух иргэн К.Баатардаваагийн орон гэрээс согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гарч яваад сураггүй алга болсон хэрэгт Д.Ганзориг гэгчийг улсын хэмжээнд эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулан холбогдох гүйцэтгэх ажлын арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

Одоогоор Тэшиг сумын харьяат Д.Ганзориг гэгч нь хаана байгаа нь тодорхойгүй сураггүй байгаа бөгөөд эрэн сурвалжлах ажлыг тасралтгүй зохион байгуулан ажиллаж, Цагдаагийн ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн албаны Эрэн сурвалжлах VII хэлтсийн даргын нэр дээр танилцуулга хүргүүлж ажлын биелэлт үр дүнг тооцуулан ажиллаж байна. Булган аймгийн цагдаагийн газраас 2018 оны эхний хагас жилийн байдлаар гал зэвсэг зарлаагүй. 2018 оны эхний хагас жилийн байдлаар тус аймгийн хэмжээнд эрэн сурвалжлалт зарлагдсан галт зэвсэг, сум, хэрэгсэл байхгүй. ASAP сангаар бусад аймгаас зарлагдсан галт зэвсгийг эрэн сурвалжлах ажлын хүрээнд сумд руу албан тоот хүргүүлэн явц үр дүнг тооцон аймаг орон нутаг руу хариуг хүргүүлэн ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд тус Цагдаагийн газраас “ASAP” сангаар улсын хэмжээнд түүх соёлын дурсгалт болон хосгүй үнэт зүйл эрэн сурвалжлаагүй. ASAP сан ашиглагдаж эхэлснээс хойш түүх соёлын дурсгалт зүйлээр 2 эд зүйл эрэн сурвалжлан ажиллаж байсан бөгөөд дээрх алдагдсан гэх бурханы талаар орон нутгийн судлах музей болон Дашчойнхорлон хийдээс лавлагаа авахад тухайн алдагдсан гэх бурхан нь ТСДЗүйл болон хосгүй үнэт зүйлээр бүртгэгдээгүй байсан. Иймд тухайн байгууллагаас нь ирүүлсэн албан тоотыг үндэслэн эрэн сурвалжлагдаж байсан 2 бурханыг эрэн сурвалжлах “ASAP” сангийн “Түүх соёлын дурсгалт болон үнэт зүйл” хэсэгт эрэн сурвалжилж байсныг “Эд зүйл” хэсэг рүү шилжүүлэн эрүүгийн хэрэг нь хэрэгсэхгүй болсон үндэслэлээр эрэн сурвалжлалтыг зогсоосон байна. ТСД болон хосгүй үнэт зүйл хэсэгт эд зүйл эрэн сурвалжлаагүй байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар Булган аймаг дахь цагдаагийн газрын эрүүгийн цагдаагийн тасгаас эрэн сурвалжлалт зарлагдсан мал, амьтан байхгүй.

Эрүүгийн цагдаагийн тасгийн хэмжээнд байгаа мөрдөн сурвалжлах, мөрдөн тагнах хэргүүд ажиллагаанд байгаа бөгөөд хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч, мөрдөгч, хэсгийн төлөөлөгч нарт чиглэл өгч хэрэгт баяжилт хийж ажиллаж байна.

2018 оны эхний хагас жилийн байдлаар Булган аймгийн Сэлэнгэ сумын нутагт Тэшиг сумын харьяат Д.Ганзориг сураггүй алга болсон хэрэгт “Бавгар” тусгайлсан нэртэй мөрдөн сурвалжлах хэрэг нээн гүйцэтгэх ажлын тоо бүртгэлд оруулж хэрэгт хийгдвэл зохих ажиллагааг явуулан сум дундын тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарт үүрэг чиглэл өгч ажиллаж байна.

Тус Цагдаагийн газрын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас эрэн сурвалжлах чиглэлээр нийт 12 даалгавар, тогтоолыг авч даалгаварт заагдсан ажиллагаануудыг хийн даалгаврын хүрээнд эрэн сурвалжилж байсан 3 этгээдийг тогтоон хуулийн хугацаанд хариуг өгч ажилласан. Одоо сураггүй алга болсон хүнийг эрэн сурвалжлах чиглэлээр аймгийн прокурорын газраас тус эрүүгийн цагдаагийн тасагт ирсэн 1 даалгаврын дагуу холбогдох ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна.

Тус Цагдаагийн газрын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас эрэн сурвалжлах чиглэлээр нийт 3 даалгавар, тогтоолыг авч даалгаварт заагдсан ажиллагаануудыг хийн даалгаврын хүрээнд эрэн сурвалжилж байсан 1 этгээдийг тогтоон хуулийн хугацаанд хариуг өгч ажилласан. Одоо сураггүй алга болсон хүнийг эрэн сурвалжлах чиглэлээр 2 даалгаврын хүрээнд ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна.

Булган аймгийн Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгийн эдийн засгийн алба нь албан үүргээ хийж хэрэгжүүлэхдээ Цагдаагийн Ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн албаны даргын тушаал, Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс 2017 оны 02-р сарын 13-ны өдөр ирүүлсэн МН-13г/328 тоот ажлын зааварчилгаа, мөн 2017 оны 12-р сарын 18-ны өдрийн МН-102/2384 тоот үүрэг, ажлын чиглэлийг удирдлага болгон хөтлөгдвөл зохих бүртгэл судалгааг хөтлөн хийх ажлаа өдөр, долоо хоног, сар, жилээр төлөвлөн Цагдаагийн газрын дарга, Эрүүгийн Цагдаагийн тасгийн даргаар батлуулж төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын талаар өдөр тутам тэмдэглэл хөтөлж тасгийн даргаар тогтмол хянуулан тухай бүр нь биелэлт үр дүнг тооцон дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн даргаас үүрэг чиглэл авч ажиллаж байна.

Эдийн засгийн албаны 2018 онд хийж хэрэгжүүлэх 38 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан гаргаж Цагдаагийн газрын даргаар батлуулан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд жилийн төлөвлөгөөнөөс салбарлаж долоо хоног, сар, улирлын төлөвлөөг гарган биелэлт, үр дүнг тооцон ажиллаж байна.

Тус тасгийн Эдийн засгийн алба нь Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2015 оны 01 тоот албан даалгавар, Эрүүгийн Цагдаагийн албаны “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх

ажлыг эрчимжүүлэх тухай” 01 тоот албан даалгавар, Эрүүгийн Цагдаагийн газрын 03-тоот гадаадын иргэн, аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 03 тоот албан даалгавар, Гадаадын иргэнтэй харилцах журам, болон Цагдаагийн Ерөнхий газрын 2016 оны 02-р сарын 19-н өдрийн 03/09 тоот “Гадаадын иргэдийг нүд үзэж тоолох” талаар ирүүлсэн ажлын чиглэл, мөн Эрүүгийн цагдаагийн албаны эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн 2017 оны 12-р сарын 18-ны өдрийн МН-10д/2384 тоот үүргийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төв, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын эдийн засгийн мөрдөгч нарын сургалтыг 2017 оны 12-р сарын 11-ний өдрөөс 13-ний өдрүүдэд зохион байгуулсан үүнтэй холбогдуулж Эрүүгийн цагдаагийн албаны дэд бөгөөд эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Ц.Ням-Очирын 2017 ооны 12-р сарын 18-ны өдрийн МН-10д/2384 тоот үүрэг, ажлын чиглэлийг ирүүлсэн. Үүний дагуу үүрэг, ажлын чиглэлийг хэрэгжүүлэх 16 заалт бүхий төлөвлөгөөг гаргаж төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

Төсвийн хөрөнгө, бонд, гадаад, дотоодын хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн санхүүжилт, мөнгөний урсгалыг дагуулж Гүйцэтгэх ажлын хүчийг оновчтой газар зохион байгуул гэсний дагуу орон нутгийн өмчийн алба / худалдан авах газар /, хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, төрийн сангийн хэлтсүүдэд туслах хүчийг зохион байгуулж ажилласан байна. Мөн аймгийн хэмжээнд 2017 онд хийгдсэн худалдан авалт, хийгдсэн ажил, олгогдсон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд Гүйцэтгэх ажлын шугамаар хяналт тавин МУ-ын ЭХТА-ын 22.1 заасан эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашигласан 2 гэмт хэргийг илрүүлэн шалгалтын ажиллагааг явуулж байна.

Мөн Цагдаагийн ерөнхий газар болон Эрүүгийн Цагдаагийн албанаас ирүүлсэн ажлын чиглэл, зааварчилгаа, Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд тус бүр төлөвлөгөө гарган цагдаагийн газрын даргаар батлуулан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Тухайлбал: 2018 оны эхний 02-р сард “Кебер гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 01 тоот албан даалгавар, Гадаадын иргэнтэй холбоотой 03 тоот албан даалгаварын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж байгууллагын судалгааг гаргаж байгууллагын санхүүжилтийн талаар ГА-ын шугамаар мэдээ, мэдээлэл цуглуулан ажиллах талаар сумдын тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарт ажлын чиглэл, зааварчилгааг хүргүүлж биелэлт үр дүнг тооцон ажилласан байна.

2018 онд Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн чиглэлээр хийж хэрэгжүүлэх 18 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан цагдаагийн газрын даргаар батлуулсан байна. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор аймгийн мэргэжлийн хяналтын газар, “Зэд” хантай дархан цаазат бүтээлийн нурууны хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах гэрээг байгуулж мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна.

Мөн аймгийн хэмжээнд ашигт малтмалын газраас 2016, 2017 онд “Цахим бүртгэлийн систем”-ээр хайгуулын тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгжүүдийн судалгааг гаргаж татвар төлөхөөс зайлсхийх, хууль бусаар ашигт малтмал олборлох, хайх, гэмт хэргүүдийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулан ажиллаж байгаа бөгөөд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн /наймаа/-нд ГА-ын шугамаар мэдээ, мэдээлэл цуглуулах, хяналт тавьж ажиллах талаар нутаг дэвсгэр хариуцсан тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарт бичгээр үүрэг өгч биелэлт үр дүнг тооцож ажиллаж байна.

2018 оны 02-р сарын 01-ны өдөр Улаанбаатар хот, 21 аймагт үндэсний хэмжээний 50,000 орчим хүн оролцуулсан эсэргүүцлийн жагсаал, цуглаан зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байгаатай холбогдуулж Эрүүгийн цагдаагийн албанаас 2018 оны 01 сарын 24-ны өдрийн Н-10/181, 2018 оны 01-р сарын 30-ны Н-10/221 тоот үүрэг ажлын чиглэлийг ирүүлсний дагуу үүрэг ажлын чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж тасгийн даргаар батлуулж төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулж үүрэг ажлын чиглэлийн биелэлтийг гаргаж Эрүүгийн цагдаагийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, цагдаагийн хурандаа Ц.Ням-Очирын нэр дээр хүргүүлсэн байна.

2018 оны эхний хагас жилийн байдлаар Эдийн засгийн алба нь эдийн засаг, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн чиглэлээр Гүйцэтгэх ажлын шугамаар нийт

45 мэдээ, мэдээлэл, илтгэх хуудсыг авсанаас 28 буюу 62.2 хувийг туслах хүчнээс, 17 буюу 37,8 хувийг эрүүгийн мөрдөгчийн илтгэх хуудсаар авсан байна. Эдийн засгийн албаны мөрдөгч нарын ГА-ын шугамаар авагдсан мэдээлэл нь Эрүүгийн цагдаагийн тасгийн авсан нийт мэдээллийн 21 хувийг эзэлж байна. 2018 оны эхний 06-р сард авагдсан мэдээллийг урьд оны мөн үетэй харьцуулбал өссөн үзүүлэлттэй байна.

Эдийн засгийн алба нь 7 холбогдогчтой 220,8 сая төгрөгний хохиролтой 6 хэргийг илрүүлэн 3 хэрэгт бүртгэлтийн хэрэг нээж 2 хэргийг харьяаллын дагуу Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн байна. Илрүүлсэн хэргийг өнгөрсөн үеийн мөн үетэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Булган аймгийн Бүрэгхангай сумын засаг дарга ажилтай Маналжав овогтой Бадам /ГВ70102710/ болон Булган аймгийн Бүрэгхангай сумын 3-р багт алт олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын хууль бус үйлдлийг тогтоох зорилгоор “Металл” тусгайлсан нэртэй мөрдөн тагнах хэргийг шалгах төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэж байна. 2018 оны 3-р улиралд багтаан дайчлах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Булган аймгийн Булган сумын 5-р багт “Дулааны станц” бариулсан гэх Улаанбаатар хотын харьяат Чойжилсүрэн овогтой Гантулга /ВЮ74011011/ гэгч нь 2014 оны 08-р сард Булган аймгийн Хутаг-Өндөр суманд болсон Засгийн газрын уулзалт зөвлөгөөний үеэр тухайн үед эрчим хүчний дэд сайдаар ажиллаж байсан Доржпүрэв гэгчид шар торонд хийж скодсон 50 сая төгрөгийг бэлнээр өгч тухайн үед Булган аймагт баригдаж байсан Дулааны цахилгаан станцын барилгын ажилд Чингис бондноос олгож буй 3 тэрбум төгрөгний дэмжлэг тусалцааг авахад та туслаач тусалсан тохиолдолд 3 тэрбум төгрөгний 10 хувь болох 300 сая төгрөгийг таньд өгнө гэж Ч.Гантулга нь дэд сайд Доржпүрэвтэй харилцан тохиролцсон гэх бөгөөд 2015 оны 12-р сард Булган аймгийн төвд баригдаж буй дулааны станцын барилгын ажлыг хийж гүйцэтгэж буй “Энержи Плас” ХХК-ны данс руу сангийн яамнаас 3 тэрбум төгрөгний санхүүжилтийг хийсэн бөгөөд тухайн үед дэд сайдаар ажиллаж байсан Доржпүрэв болон сангийн яаманд түлш эрчим хүчний асуудал хариуцсан мэргэжилтэн Цэнд-Аюуш нарт Ч.Гантулга нь тус бүрт нь 150 сая төгрөг өгсөн гэх.

“Энержи плас” ХХК-ний захирал Ч.Гантулга гэгч нь Булган аймагт баригдаж буй дулааны цахилгаан станцад зарцуулагдах улсаас авсан 3 тэрбум төгрөгнөөс 1 тэрбум орчмыг нь тухайн үед тоног төхөөрөмжийг нийлүүлж угсарч байсан БНХАУ-ын Цоог ван захиралтай “Zheng tai boiler” компанийн данс руу техник хэрэгсэл худалдаж авах, урьд өмнө байсан өрийг төлөх нэрийдлээр шилжүүлж өөрийн эхнэр болох Нэргүй овогтой Мягмарсүрэн / ЧЖ73100301 / дансаар 500 орчим сая төгрөгийг нь буцааж авч газар тариалангийн наймаанд буюу арабс худалдан авч зарж борлуулан хувьдаа ашигласан, улсаас орж ирсэн 3 тэрбум төгрөгний зарцуулалтын тайланг хуурамч материал бүрдүүлэн гаргаж нэлээдгүй хэсгийг нь хувьдаа завшсан, уг дулааны станц бүрэн ашиглалтанд ороогүй байхад улсаас өгөх 3 тэрбум төгрөгийг 100% гаргуулж авсан, 2018 оны улсын төсөвт уг дулааны станцын ажилд 800 сая төгрөгийг Эрчим хүчний яамны албан тушаалтан Болдхүү болон өөр бусад хүмүүст авлигал өгч төсөвт суулгуулсан, энэ хууль бус үйлдэлд нь сангийн яамны газрын дарга Д.Доржсэмбэд нь холбоотой гэх мэдээлэлд мөрдөн тагнах хэрэг нээхээр Гүйцэтгэх ажлын мэдээ, мэдээлэл цуглуулан ажиллаж байна.

Тус цагдаагийн газрын эдийн засгийн алба нь 2018 оны эхний хагас жилийн байдлаар 900,000 /есөн зуун мянга/-н төгрөгийг Гүйцэтгэх ажлын зардалд зарцуулсан байна.

2018 онд тус Цагдаагийн газраас зохион байгуулж явуулах нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнд эдийн засгийн албанаас Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор 2018 оны 06-р сард “Мод”, 8-9-р сард “Тарвага”, 10-11-р сард “Хяналт-шийдвэрлэлт” Авлигын эсрэг болон эдийн засгийн гэмт хэргийг илрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд 2018 оны 2-р улиралд “Газар”, 1-р улиралд “Мэдээлэл” хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар Цагдаагийн газрын төлөвлөгөөнд тусгуулан төлөвлөгөөний дагуу холбогдох ажиллагааг хийж гүйцэтгэж байна.

Эрүүгийн Цагдаагийн албаны эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс 2018 оны 03-р сарын 09-ны өдрийн МН-10/561 алба бичгээр ирүүлсэн улсын хэмжээнд явагдах буй “Сан тулгалт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд арга хэмжээг хэрэгжүүлэх салбар

төлөвлөгөөг боловсруулан гаргаж дэд бөгөөд ЭЦТ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Гантөмөрөөр батлуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд.

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн даатгалын сангаас нөхөн төлбөр гаргуулан авах тусгай зөвшөөрөлтэй аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллага, аж ахуй нэгж, эмийн сангуудын судалгааг 2015 оноос хойшхи байдлаар гаргуулан авахаар холбогдох газруудад халхавчтайгаар албан тоот хүргүүлж судалгааг авч холбогдох ажиллагааг хийж гүйцэтгэн танилцуулгыг эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт хүргүүлэн ажилласан.

Монгол улсын зарим аймгийн нутаг дэвсгэрт 2012-2018 оны 1-р улирлын хооронд малын гоц халдварт /шүлхий, цэцэг, мялзан, шүлхий / өвчин гарсантай холбогдуулан халдварт өвчний эх үүсвэр, тархалт, түүнтэй тэмцэх чиглэлээр төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг газар дээр нь шалгаж, гэмт хэрэг зөрчлийн шинжтэй аливаа үйлдлийг илрүүлэх, буруутай этгээдийг эрүүгийн хариуцлагад татах зорилгоор Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газраас “Нөхөн төлбөр” нэгдсэн арга хэмжээг явуулах удирдамж, төлөвлөгөө, зааварчилгааг 2018 оны 03-р сарын 03-ны өдрийн МН-10/795 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Үүний дагуу “Нөхөн төлбөр” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хийж хэрэгжүүлэх 13 заалт бүхий салбар төлөвлөгөөг дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу холбогдох ажиллагааг хийж гүйцэтгэн холбогдох танилцуулгыг эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт 2018 оны 05 сарын 20 өдрийн МН-38/34 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн хэрэгжилт, химийн хорт, аюултай бодис ашигласан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаар авагдсан мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийж нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор Улсын хэмжээнд “Бодис-2018” хэсэгчилсэн арга хэмжээг явуулах 2018 оны 04-р сарын 23-ны өдрийн 11/164 үүрэг, ажлын чиглэлийн дагуу нэгдсэн арга хэмжээний хүрээнд хийж хэрэгжүүлэх 12 заалт бүхий салбар өлөвлөгөөг гаргаж, хамтарсан шалгалт хийх 6 заалт бүхий удирдамж, төлөвлөгөөг боловсруулан Цагдаагийн газрын дарга Мэргэжлийн хяналтын газрын даргаар батлуулсан байна. Булган аймгийн Мэргэжлийн хяналтын газрын, Онцгой байдлын газар, Тагнуулын хэлтэстэй хамтран Булган аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд химийн хорт болон аюултай бодис ашиглан уул уурхай, газар тариалын, үйлдвэр үйлчилгээ, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн , аж ахуй нэгжийн судалгааг гаргуулан ажиллахад Булган аймгийн хэмжээнд химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэдэг 3 аж ахуй нэгж байгууллага байгаа талаар судалгааг гаргасан. Үүний дагуу дээрх 3 аж ахуй нэгж байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгалтын ажиллагааг хийж гүйцэтгэн холбогдох танилцуулгыг Улсын мөрдөн байцаах газрын Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст хүргүүлэн ажилласан байна.

“Маршрут” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймаг, орон нутагт нөхөрлөл нэрээр болон гар аргаар алт олборлож байгаа гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээдүүд, бүлэг бөөгнөрөлийн талаар гүйцэтгэх ажлын шугамаар судалгаа хийх, мэдээ, мэдээлэл цуглуулж хяналтанд авах, хууль бус үйл ажиллагааг илрүүлж таслан зогсоох , оргодол этгээдүүдийг эрэн сурвалжилж баривчлах зорилгоор Эрүүгийн цагдаагийн албаны III-р хэлтсээс “Орон нутаг” хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2018 оны 05-р сарын 23-ны өдрийн МН-10д/1217 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Үүний дагуу Үүний дагуу “Орон нутаг” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд хийж хэрэгжүүлэх 20 заалт бүхий салбар төлөвлөгөөг дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Гантөмөрөөр батлуулан төлөвлөгөөний дагуу холбогдох ажиллагааг хийж гүйцэтгэсэн байна.

Булган аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд алт олборлох үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, нөхөрлөл, иргэдийн талаарх дэлгэрэнгүй судалгааг сумдын хэсгийн төлөөлөгч, мэргэжлийн байгууллагуудтай хамтран гаргахад аймгийн хэмжээнд нийт нөхөрлөл нэрээр идэвхтэй 8 үйл ажиллагаа явуулж байгаа 8 нөхөрлөл, 6 аж ахуй нэгж байгууллагууд байна. Булган аймгийн хэмжээнд ашигт малтмал олборлох аж ахуй нэгж байгууллагуудын 92% нь Булган аймгийн Бүрэгхангай суманд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Булган аймгийн Бүрэгхангай сумын 3-р баг нутаг “Туулын гүүрнээс хойшоо

“Ар тээл” гэх газар хүртэл ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 16, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 14 аж ахуйн нэгж байгууллага байгаагаас ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 6 уурхай алт олборлох чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. 2018 онд “Гэрэлт шинэчлэл” ХХК, “Гачуурт” группийн охин компани болох “ГБНБ” ХХК, “Төсөлч” ХХК, “Хамтын эх булаг” ХХК, “Хос хас” ХХК, “Монпил” ХХК, Баян Базараагийнх гэх “Эко Алтан заамар” гэх компаниуд үйл ажиллагаа явуулж байна.

Булган аймгийн Бүрэгхангай суманд 2018 бичил уурхайгаар “Дархан үржих”, “Дархан бодь”, “Дархан Ач хангай”, “Шар шувуут уул”, “Баялаг Арвижих өгөөж”, “Цагаан эрэг” нөхөрлөлүүд нийт 120 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна гэх судалгаануудыг гаргасан. Судалгаанд үндэслэн хуулийн дагуу болон хууль бусаар үйл ажиллагаа явуулж байгаа хэдэн аж ахуйн нэгж, иргэд байгаа талаар гүйцэтгэх ажлын шугамаар мэдээ, мэдээлэл цуглуулах, баримтжуулж эрүүгийн хариуцлагад татах, алт олборлох үйл ажиллагаа буй сэжигтэй этгээдүүдийн гарын дардас, гэрэл зураг дэлгэрэнгүй биеийн байцаалт бүхий судалгааг хийх зорилгоор Булган аймгийн Шүүхийн шинжилгээний албатай хамтран 2018 оны 06-р сарын 16-18-ны хооронд Булган аймгийн Бүрэгхангай суманд ажиллаж нийт Бүрэгхангай сумын 3-р багт алт олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 8 нөхөрлөлийн 126 иргэний гарын дардсыг авч санд папилон оруулан Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хүргүүлж гарын мөрний санд байгаа эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргүүдийн хэргийн газраас олдсон мөрүүдтэй харьцуулахаар шинжилгээнд хүргүүлсэн, бичил уурхайд ажиллаж байгаа нэр бүхий 126 иргэнийг анкетийн дагуу бүртгэж, гэрэл зургийн аргаар бэхжүүлэн дэлгэрэнгүй судалгааг хийж ажилласан байна.

2018 оны эхний улиралд тус тасаг хэрэг хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуулийн хүрээнд явуулж байна. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн хэргүүдээс 47 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах саналтай аймгийн прокурорын газарт шилжүүлж, 13 хэргийг хуулийн зүйл заалтаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэн, 6 хэргийг шүүх рүү шилжүүлж, 2 хэргийг харъяаллын дагуу бусад газар хэлтэс, тасагт шилжүүлэн шийдвэрлэж, 33 хэргийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтай шийдвэрлэж, 343.300.000 төгрөгний хохиролтой хэргийг илрүүлж, 11.1400.000 төгрөгийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж, 93 холбогдогчтой гэмт хэрэг, үйлдлийг илрүүлэн шийдвэрлэж, 2018 оны эхний хагас жилийн байдлаар хэргийн илрүүлэлт 48.4 хувьтай байна.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Илрүүлэлт-Шийдвэрлэлт” нэгдсэн арга хэмжээ, “Хамтдаа-шийдвэрлэе” хэсэгчилсэн арга хэмжээ, “Бүтээлч ажил-80” зэрэг аяны хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт зохион явуулах удирдамж төлөвлөгөө гарган дэд даргаар ахлуулсан ажлыг хэсгийг цагдаагийн газрын даргын тушаалаар байгуулан зохион байгуулан ажилласан. Арга хэмжээний хүрээнд тасгийн алба хаагчдаас эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэх, эрэн сурвалжлагдаж байгаа оргодол этгээдийг барих чиглэлээр алба хаагч нарт ажлын чиглэл, үүрэг хүргүүлэн хэрэгжилт үр дүнг 7 хоног тутам тооцон ЦЕГ-ын мэдээлэл шуурхай удирдлагын төвд арга хэмжээний мэдээг өдөр бүр өгч илрүүлсэн хэрэг, эрэн сурвалжилж олж баривчилсан оргодол этгээдийг мэдээлэл судалгааны тоо бүртгэгчээр санд тогтмол тулгалт хийлгэн дүнг нэгтгэн танилцуулан ажилласан.

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан түдгэлзүүлсэнээс сэргээн шалгаж байгаа хэрэг бүртгэлтийн хэргүүдийн эзэн холбогдогчийг олж тогтоон шийдвэрлэлтийг эрчимжүүлэх зорилгоор Аймгийн прокурорын газар, Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасаг, Мөрдөн байцаах тасаг хамтран **“Хамтдаа-Шийдвэрлэе”** нэгдсэн арга хэмжээг 2018 оны 03 дугаар сарын 07-ний өдрөөс 04 дүгээр сарын 22-ний өдөр хүртэл 45 хоногийн аяныг Булган аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Дээрх аяны хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэн ажиллаж байна. Үүнд:

Гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий алба хаагч бүрийг түдгэлзүүлсэнээс сэргээн шалгаж байгаа эрүүгийн хэргүүдийн эзэн холбогдогчийг олж тогтоон хэргийг эцэслэн шийдвэрлэх, эзэн холбогдогч нь тодорхой удааширч байгаа хэргийг шуурхай хуулийн хүрээнд шийдвэрлэх шалгаж байгаа хэргийг цөөрүүлэх ажлын ачааллыг бууруулах зорилгоор хэсгийн төлөөлөгч, эрүүгийн мөрдөгч, хэрэгт хяналт тавьж буй хяналтын прокурор нарт хариуцуулж өгсөн.

Эрүүгийн хэргүүдэд эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн тулгалтыг нэг бүрчлэн хийж, үйлдэгдэж байгаа хулгайлах гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх чиглэлээр ажлын хэсгийг зохион байгуулан ажиллагааны үр дүнг тооцон Нийслэл Улаанбаатар хот руу явуулж холбогдох ажиллагааг хийлгүүлж ажилласан. Арга хэмжээний хүрээнд эрүүгийн хэрэгт эрэн сурвалжлагдаж байсан Тэгшээ овогтой Баянцагаан, Баасансүрэн овогтой Амартүвшин, Чинбатын Батдорж нарыг тус тус дайчлан баривчилж хэргийг шилжүүлсэн.

ГА-ын мөрдөн тагнах хэргийн этгээд Баасан овогтой Баярбат, Гантулга овогтой Батбаяр нар Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрт 3 удаагийн үйлдлээр орон байр, малын хулгайн гэмт хэрэг үйлдсэнийг илрүүлэн эрүүгийн хрэгэ үүсгэж, ялагдагчаар татан мөрдөн байцаалтанд шилжүүлэн цагдан хорих арга хэмжээг авахуулж цагдан хорих байранд ГА-ын камерын баримтжуулалтын арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна.

Булган аймгийн Булган суманд насанд хүрээгүй О.Мөнгөнцэцэг нь бусдад хүчиндүүлсэн эрүүгийн 171500241 дугаартай хэргийг УБ хотын харьяат БЗД-ийн харьяат Цэрэндорж овогтой Батзориг гэгч үйлдсэн болохыг нөхөн илрүүлж харьяаллын дагуу УБ хотын БЗД-ийн цагдаагийн 1 дүгээр хэлтэст шилжүүлэн шийдвэрлэсэн.

ОХУ-ын Буриад Улсын харьяат 14 настай Екатерина Иванова Львовна нь Хангал сумын нутагт байрлах “Найрамдлын Эрдэнэс” нэртэй зусланд амарч байхдаа үл таних залууд хүчиндүүлсэн хэргийг Орхон аймгийн харьяат Б.Бат-Лхагва, А.Төрмөнх нар нь үйлдсэн болохыг илрүүлэн одоо шалгалтын ажиллагаа явагдаж байна.

Арга хэмжээний хүрээнд 181500085 дугаартай хэрэгт хууль бусаар мод бэлтгэж тээвэрлэсэн П.Цэнд-Очир, 181500088 дугаартай хэрэгт хууль бусаар мод бэлтгэж тээвэрлэсэн Ч.Мөнхтөр, 181500087 дугаартай хэрэгт хууль бусаар мод бэлтгэж тээвэрлэсэн Д.Бат-Чулуун нарыг илрүүлэн яллагдагчаар татах саналтай аймгийн прокурорын газарт шилжүүлэн шийдвэрлэсэн. Мөн 181500057 дугаартай орон байрны хулгайн хэрэгт Б.Өсөрбахбаяр гэгчийг холбогдуулан шалгаж хэргийн халуун мөрөөр илрүүлэн яллагдагчаар татах саналтай аймгийн прокурорын газарт тус тус шилжүүлэн ажилласан байна.

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрээс сураггүй алга болж Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрээс олдсон Батбилэгийн цогцос олдсон эрүүгийн 201706000045 дугаартай хэрэгт ажлын хэсгийн гишүүдтэй хамтран холбогдох шалгалтын ажиллагааг зохион байгуулан Б, Т нарыг холбогдуулан шалгаж байна.

Хэргийн илрүүлэлт 2018 оны 02 дугаар сарын байдлаар 22.9 хувьтай байсан хэргийн илрүүлэлт шийдвэрлэлтийг ахиулах чиглэлээр нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж ажилласанаар 2018 оны 04 дүгээр сарын 10-ны байдлаар хэргийн илрүүлэлт 30 хувьтай байна.

Мөн 2018 оны 04 дүгээр сард шийдвэрлэх хэргийн график төлөвлөгөөг боловсруулан батлуулж Булган аймгийн Прокурорын газарт хүргүүлэн ажиллаж, хэрэг бүртгэлтийн ажиллагаанд гарч байгаа зөрчил дутагдал цаашид анхаарах асуудлын чиглэлээр Булган аймгийн ПГ-ын хурлын танхимд эрүүгийн мөрдөгч, мөрдөгч нарын хамтарсан зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулан ажилласан. Тус зөвлөгөөнөөр 2018 оны 04 дүгээр сарын дундуур прокурорын байгууллагатай хамтарсан зөвлөгөөнийг дахин зохион байгуулах, дээрх зөвлөгөөнөөр хэсгийн төлөөлөгч нарыг бүрэн хамруулан зохион байгуулахаар тогтов.

#### **-Мөрдөн байцаах албаны чиглэлээр:**

Тайлангийн хугацаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 62 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 54, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 8, өмнөх оны үлдэгдэл 16 хэрэг бүртгэлтийн хэрэг дээр шинээр 54 хэрэг бүртгэлтийн хэрэг нээж нийт 70 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулснаас эрүүгийн хэрэг үүсгэн шууд яллагдагчаар татсан 16, хэрэгсэхгүй болгох саналтай 38, одоо 12 хэргийн үлдэгдэлтэй байна.

Өргөдөл гомдол, мэдээллийн үлдэгдэлгүй 100 хувь хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.

Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нийт 79 хэргээс 71 холбогдогчтой 57 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, харьяаллын дагуу 9 холбогдогчтой 7 хэргийг өөр бусад газар, хэлтэст шилжүүлж одоо 18 холбогдогчтой 15 хэргийн үлдэгдэлтэй байна.

Шүүхээс 6 холбогдогчтой 4 хэрэг, прокуророос нэмэлт мөрдөн байцаалтанд буцсан 6 холбогдогчтой 6 хэргийг хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

2018 оны эхний хагас жилийн байдлаар Мөрдөн байцаах тасагт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.14 дүгээр зүйлийн 31.14-1.1, 31.14-1.2, 31.14-1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн хэрэг байхгүй болно.

Гэмт хэргийн улмаас иргэн аж ахуйн нэгж байгууллагад 385,3 сая төгрөгийн хохирол учирснаас 315,8 сая төгрөгийн хохирлыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж МУ-ын ЭХХШТХ-н 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршигийг арилгуулах, болон хөрөнгө, нуугдмал эд хөрөнгийн олж тогтоон эд хөрөнгө хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор 21,0 сая төгрөгний эд хөрөнгийг битүүмжлэн ажилласан. Эхний хагас жилийн байдлаар гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлт 88,9 хувьтай байна.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор мөрдөгчийн мэдэгдэл 57-г бичиж хариуг 100 хувь авч ажилласан байна. Мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр шалгах ажиллагааг 10 удаа зохион байгуулсан.

Мөрдөн байцаах тасгийн дарга МУ-ын ЭХХШТХ-н 6.3 дугаар зүйлд заасны дагуу хэргийн материалтай биечлэн танилцах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, мөрдөгч нарт дэмжлэг үзүүлэх зорилгоор 26 хэрэгт бичгээр зааварчилга өгч биелэлтийг нь хангуулан ажилласан.

ЦБҮАЖ код 306-д заасны дагуу мэргэжлийн зөвлөлөөс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байгаа ээдрээ төвөгтэй, олон үйлдэл холбогдогчтой, олон хүн хохирсон, шийдвэрлэхэд бэрхшээл учирч байгаа хэргүүдийг уншиж мэргэжлийн болон мөрдөн байцаалтын арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор 7 хэрэгт зааварчилга өгч, шинээр хэрэгжиж буй МУ-ын Эрүүгийн хууль, ЭХХШТХ-г хэрэгжүүлэхэд гарч буй зөрчил дутагдлыг арилгах зорилгоор нийт мөрдөгч нарт 10 удаа зааварчилга өгсөн.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинээр Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай багц хуулиуд хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг 5 хоногийн хугацаанд, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийг ажлын 3 хоногийн хугацаанд шалгаж шийдвэрлэхээр тусгасан зэрэг өргөдөл гомдол шалгаж шийдвэрлэхтэй холбоотой хуулийн хэрэгжилтийг нэг мөр хангаж ажиллах талаар нийт гэмт хэрэг зөрчил шалгах эрх бүхий алба хаагчдад Прокурорын газартай хамтарсан сургалтыг зохион байгуулсан.

Гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг ахиулах алба хаагчдын ажлыг эрчимжүүлэх зорилгоор Аймгийн прокурорын газартай хамтран “Хамтдаа шийдвэрлэе” хэсэгчилсэн арга хэмжээг 2018 оны 03-р сарын 04-ний өдрөөс эхлэн 4 хоногийн хугацаатай зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн прокурорын газарт шинэ хууль хэрэгжиж байгаатай холбогдуулан гарч байгаа хүндрэл бэрхшээл цаашид авч хэрэгжүүлэх арга замын талаарх уулзалтыг 2018 оны 01 дүгээр сарын 20-ний өдөр удирдах албан тушаалтны хүрээнд зохион байгуулсан.

Уулзалтанд Цагдаагийн газрын дарга, аймгийн ерөнхий прокурор, орлогч прокурор, Дэд бөгөөд ЭЦТ-н дарга, МБТ-н дарга нар оролцсон.

Шинэ хуулийн хэрэгжилттэй холбоотой Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сар бүрийн 05-ны өдөр аймгийн прокурорын газартай хамтарсан зөвлөгөөн зохион байгуулж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гарч байгаа зөрчил дутагдал, цаашид авч хэрэгжүүлэх ажил арга хэмжээний талаар хэлэлцэн ажиллаж хэвшсэн.

Нийт 6 удаа хамтарсан зөвлөгөөн зохион байгуулан ажилласнаар 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн үндэслэлээр аймгийн прокурорын газраас Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах тасагт арга хэмжээ тооцуулах албан бичиг, шаардлага аваагүй болно.

#### **-Хэрэг бүртгэх албаны чиглэлээр:**

2018 оны эхний хагас жилийн байдлаар Хэрэг бүртгэх тасаг нь харьяалан шалгаж шийдвэрлэх зөрчлийн шинжтэй 42 гомдол, мэдээлэл хүлээн авсанаас 13 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 4 зөрчлийг хялбаршуулсан журмаар торгуулийн арга хэмжээ авч шийдвэрлэсэн, 16 гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 3 гомдол, мэдээллийг харъяаллын дагуу бусад тасагт шилжүүлж шийдвэрлэсэн.



Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/11, 2018 оны А/35 дугаар тушаал, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2018 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 2/48 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Үүрэг, ажлын чиглэл”, Хэрэг бүртгэх албаны Дэд бөгөөд дүн шинжилгээ, үнэлгээ хяналт шалгалтын хэлтсийн даргын 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 12 а/104 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Үүрэг, ажлын чиглэл”-үүдийг тус тус хүлээн авч хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа.

Цагдаагийн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/08 дугаартай тушаалаар Цагдаагийн газрын Захиргааны удирдлагын тасгийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулж, 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн хугацаанд Хэрэг бүртгэх тасагт харъяалагдан шалгаж байсан зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл, зөрчлийн хэргийг Нийтийн хэв журам хамгаалах тасагт шилжүүлэх, Мөрдөн байцаах тасаг, Эрүүгийн цагдаагийн тасгуудад шалгаж байсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл, эрүүгийн хэргүүдийг Хэрэг бүртгэх тасагт шилжүүлэн авах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, гаралтыг саармагжуулах болон эзэн холбогдогч нь тогтоогдоогүй, оргон зайлсан үндэслэлээр түдгэлзүүлсэн хэргүүдийн эзэн холбогдогчийг олж тогтоон хэргийн шийдвэрлэлтийг ахиулах зорилгоор “Хуулийн хэрэгжилт”, “Илрүүлэлт-Эрэн сурвалжлалт-Шийдвэрлэлт” нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийн төлөвлөгөөг гарган Цагдаагийн газрын даргаар батлуулан хөдөөгийн нийт сумдад арга хэмжээний хүрээнд өдөр бүр өгөх ажлын мэдээ, үүргийн хамт төлөвлөгөөг хүргүүлэн биелэлт үр дүнг тооцон ажилласан.

Хэрэг бүртгэх тасаг нь 2018 оны энхий хагас жилийн байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 36 гомдол, мэдээлэл хүлээн авч нийт хүлээн авсан гомдол мэдээллийг хуулийн анхны хугацаанд шалгаж 29 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг, 4 гомдол мэдээлэлд мөрдөн байцаалтын хэрэг нээж, 3 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж хааж нийт хүлээн авсан гомдол мэдээллийг хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэн ажилласан.

2018 оны 06 дугаар сарын байдлаар нийт 47 хэрэг бүртгэлтийн хэрэг шалгаснаас хэрэг бүртгэлтийн 5 хэргийг хааж, харьяаллын дагуу 1 хэрэг шилжүүлж, 28 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, хэрэг бүртгэлтийн 12 хэргийн үлдэгдэлтэй байна. Тайлант хугацаанд харьяалалын дагуу 1 хэрэг хүлээн авч хэрэг бүртгэлтийн хаасан хэргээс 2 хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокуророос сэргээн ирүүлсэн.

Түдгэлзүүлсэн болон түдгэлзүүлсэнээс сэргээсэн хэрэг бүртгэлтийн хэрэг байхгүй, өмнөх оны дугаартай 5 хэрэг бүртгэлтийн хэрэг хүлээн авч шалгаж ажиллаа.

Шалгагдаж байгаа хэргүүдээс хэрэгт сэжиглэгдсэн этгээдийн оршин суух хаяг тодорхойгүй гэх үндэслэлээр 3 хэргийн хэрэг бүртгэлтийн хугацааг сунган шалгагдаж байсан. Үүнд:

2017 оны 12 дугаар сарын 31-ны өдөр Булган аймгийн Орхон сумын 3 дугаар багт М.Гэрэлт-Од нь нагац дүү Б.Учралзаяаг зодож хөнгөн хохирол учруулсан 181500015 тоот хэрэг.

2017 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Булган аймгийн Бүрэгхангай сумын 3 дугаар багийн нутаг Туул голын гүүрний орчим алтны уурхайд ажиллаж байсан Ж.Батдорж нь хамт ажиллаж байсан Д.Ганбатыг зодож биед хөнгөн хохирол учруулсан 1715000145 тоот хэрэг.

2017 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг Чин Хайрхан төвийн караокед Хишиг-Өндөр сумын харьяат Г.Болд-Эрдэнэ нь иргэн А.Баярсайханыг хутгалж биед нь хүнд хохирол учруулсан 1715002350089 тоот хэргүүд байна.

Дээрхи хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулан шалгаж байгаа сумдын хэсгийн төлөөлөгч нарт Цагдаагийн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 38/01-258 дугаартай албан бичиг, 2018 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 38/01358 дугаартай “Үүрэг, ажлын чиглэл”, 2018 оны 03 дугаар 24-ны өдрийн зааварчлагуудаар гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийн шуурхай эрэн сурвалжилж олж тогтоон эрүүгийн хэргүүдийг шийдвэрлэх талаар ажлын чиглэл, үүргүүдийг хүргүүлэн

ажилласанаар 1715000145 тоот хэрэгт сэрдэгдсэн холбогдогч Ж.Батдорж, 181500015 тоот хэргийн холбогдогч М.Гэрэлт-Од нарын мэдээллийг ASAP санд оруулж, харьяалах хэсгийн төлөөлөгч нар ажлын хэсэг болон хамтарч эрэн сурвалжлах ажлын төлөвлөгөөг гарган зохион байгуулан ажилласанаар холбогдогч нарыг олж тогтоон хэргийг шийдвэрлэн ажиллаж 1715002350089 тоот хэргийн холбогдогч Турк улсруу гарсан тул хэрэг бүртгэлтийн хугацааг сунган шалгаж байна.

2018 оны байдлаар мөрдөн байцаалтын нийт 40 холбогдогчтой 37 эрүүгийн хэрэг шалгаснаас 36 хэргийг хялбаршуулсан журмаар шалгаж шүүхэд шилжүүлэх мөрдөгчийн саналтай шилжүүлж, 1 хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэн ажилласан. Шүүхэд шилжүүлэн шийдвэрлэсэн эрүүгийн хэргээс гологдолоор нэмэлт ажиллагаа хийхээр шүүхээс буцсан хэрэг байхгүй.

Тайлангийн хугацаанд шүүхээс нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр буцаасан 2017 оны дугаартай 2 хэргийг 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авч мөрдөн шалгах ажиллагааны 1 дүгээр хугацаа сунгуулан мөрдөн шалгах ажиллагааг явуулан шалгаж шүүхэд шилжүүлэх саналтай шийдвэрлэсэн.

2018 оны 06 дугаар сарын байдлаар нийт шалгасан хэрэг бүртгэлтийн хэргийн 73.2 хувийг, мөрдөн байцаалтын хэргийн 100 хувийг хуулийн шийдвэрлэсэн.

Тус Хэрэг бүртгэх тасагт тайлант хугацаанд эзэн холбогдогч нь тогтоогтоогүй, оргон зайлсан үндэслэлээр түдгэлзүүлсэн мөрдөн байцаалтын хэрэг байхгүй, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан 1 яллагдагчтай, хилийн хориг тавигдсан яллагдагч байхгүй болно.

#### **-Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:**

Булган аймаг дахь цагдаагийн газраас Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 339, 340 дүгээр тогтоолын дагуу Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах талаар хийх дадлага сургуулилтанд 2018 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 16.00 цагаас 17.00 цагийн хооронд бие бүрэлдэхүүн бүрэн хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын орлогч даргаас 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/303 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Дадлага сургууль зохион байгуулах тухай” албан бичгийг хүлээн авч алба хаагч нарт танилцуулан, алба хаагчдын албаны болон хувийн бэлтгэлийг хангуулан ажиллалаа.

Алба хаагчдын газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах чиглэлээр ажиллах ажлын төлөвлөгөөг танилцуулан үүрэг, ажиллах чиглэлийг тодотгон өгч үүрэгжүүллээ. Мөн гамшгийн үед алба хаагчдын албаны болон хувийн бэлтгэлийг хангуулах зорилгоор алба хаагчдын аранзны байдалд үзлэг шалгалтыг явуулж дүнг нэгтгэн Цагдаагийн газрын дарга болон аймгийн онцгой байдлын газрын хяналт тавьж буй алба хаагчид дүнг нэгтгэн өгсөн.

Гамшгийн үеийн эрсдлийг бууруулах дадлага сургууль улсын хэмжээнд 2018 оны 03 дугаар 29-ны өдрийн 16.00 цагт “Зарлан мэдээлэх” дохионы зарлан мэдээллээр алба хаагчдыг газрын байрнаас гарган байрны баруун талд байрлах жагсаалын талбайд жагсаан аранзанд үзлэг шалгалт хийж дүн мэдээг аймгийн онцгой байдлын газарт танилцуулгаар хүргүүлэн ажиллаа.

Гамшгийн үеийн зарлан мэдээллийн хоёр дахь дохио буюу 16.15 минутанд алба хаагчдыг газар хөдлөлтийн бүсээс /Цагдаагийн газрын байрнаас/ 5-7 минутанд гаргаж аюулгүй газарт хүргэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Гамшгийн үеийн зарлан мэдээллийн хоёр дахь дохио буюу 16.15 минутанд алба хаагчдыг газар хөдлөлтийн бүсээс /Цагдаагийн газрын байрнаас/ 5-7 минутанд гаргаж аюулгүй газарт хүргэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Танхимын болон дадлага сургалтыг 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдөр аймгийн ОБГ-ын ажилтан ахлах дэслэгч Б.Ганбаярыг урьж алба хаагчдын дунд Гамшиг ослын үед хэрхэн ажиллах талаар сургалт хийлгэсэн.

Зарлан мэдээллийн 1 дэхь дохио буюу 16.00 минутанд алба хаагчдыг аюулгүй бүсэд хүргэсний дараа нэрсээр тулган бүртгэхэд ирвэл зохих 85 алба хаагчаас хөдөө албан ажлаар явсан 27, өвчтэй 3 алба хаагч, ээлжийн амралттай 3, бусад 52 алба хаагч,

хөдөлгөөнт эргүүлийн 2 автомашин, гар станц-4, суурин станц-1-тэйгээр бүрэн цугларч дадлага сургуулалтыг ямар нэгэн зөрчил дутагдалгүй зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд Рашаант, Гурванбулаг, Бугат, Булган, Сайхан, Хишиг-өндөр суманд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний улмаас хорио цээрийн дэглэм тогтоож, нийт 45 постонд цагдаагийн газраас 27 албан хаагч, 7 автомашин, үүрэг гүйцэтгэж байна. Постонд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарыг 7-14 хоногийн хугацаатай постонд үүрэг гүйцэтгэх томилгоог хийж алба хаагч бүрт баталгаа зааварчилгааг өгч цагдаагийн газрын даргаар батлуулан ажиллаж байна. Булган суманд хорио цээрийн дэглэм тогтоосонд хяналт тавих 11 хяналтын цэгт /пост/ цагдаагийн 2 офицер, 9 ахлагч, нийт 11 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна. Хорио цээрийн хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарт Цагдаагийн газрын даргаас 2018 оны 02 дугаар 28-ны өдрийн 38/01-322 албан бичгээр 8 заалт бүхий ажлын үүргийг хүргүүлэн, алба хаагч бүрээр сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх талаар **баталгаа** гаргуулан гарын үсэг зуруулж баталгаажуулж ажилласан. Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа З.Дашдаваагийн 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 4/1175 албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийг цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд танилцуулан, хорио цээрийн дэглэм тогтоох хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарт хүргүүлэн ажилласан. Хорио цээрийн дэглэм тогтоох хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарт цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа З.Гомбо, Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Ж.Эрдэнэ-Очир, Олон нийттэй харилцах ахлах байцаагч, цагдаагийн хошууч Э.Ариунчимэг, сэтгэл зүйч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Батмөнх, эмч, цагдаагийн дэслэгч Б.Баярчимэг нарын бүрэлдэхүүнтэйгээр хяналтын цэгүүдээр тойрон, үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарын биеийн эрүүл мэндийн байдалд үзлэг хийж, сэтгэл зүйчээс ярилцлага хийн, мал, амьтны гоц халдварт шүлхий өвчинөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хүргүүлэн, Зөрчлийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Аймаг, сумын Засаг даргын захирамж, Цагдаагийн Ерөнхий Газрын дэд даргаас өгсөн ажлын чиглэл, Цагдаагийн газрын даргаас өгсөн үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг даалган эдгээр материалыг гарын авлага болгон өгч, сахилга ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх талаар баталгаа гаргуулан халуун аарц, хоолоор үйлчлэн дэмжлэг үзүүлэн ажилласан. 2018 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/103 тоот захирамжаар байгуулагдсан мал, амьтаны гоц халдварт “Шүлхий” өвчинөөр өвчилсөн байж болзошгүй малыг олж тогтоох “Тандалт”-ын багт цагдаагийн газраас ахлах байцаагч хэсгийн байцаагч нараас 5-ыг томилон аймгийн онцгой комиссын гишүүд, мэргэжилтний байгууллагын ажилтан нартай хамтран үзлэг, тандалт, вакцинжуулалт, ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Архидан согтуурахтай, гэр бүлийн хүчирхийлэл, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 10 төрлийн 2684ш санамж, зөвлөмжийг аймаг, сумын ГХУСА33-ийн 310,000 төгрөгийн санхүүжилтээр тус тус хэвлүүлэн үйл ажиллагаандаа хэрэглэсэн. Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн дунд “Архигүй ирээдүй”, “Хулгайлах гэмт хэргээс сэрэмжилье” сэдэвт гар зураг, зохион бичлэгийн уралдаан, хууль эрх зүйн мэдлэгийг бататгах АХА, “Асуулт-хариулт” тэмцээн зэрэг ажилд аймаг, сумын ГХУСА33-өөс 420,000 төгрөгийн санхүүжилтээр тус тус зохион байгуулж, цахим хуудсаар сурталчлан ажиллалаа. Аймгийн хэмжээнд “Хуулиа мөрдье” арга хэмжээний хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр tv9 телевизээр 1 удаа, радиогоор 12 удаа, сэрэмжлүүлэг мэдээ, сонин хэвлэлээр 2 удаа сэрэмжлүүлэг мэдээллийг иргэдэд хүргэн сурталчилж ажилласан. Юнителын “Web2SMS” үйлчилгээгээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг мэдээг аймгийн удирдлага, агентлаг байгууллагуудын дарга, эрхлэгч, хэвлэл мэдээллийн байгууллагын эрхлэгч, ажилтан, 16 сумын Засаг дарга, аймгийн ИТХ-ын тэргүүлэгч, багийн Засаг дарга нар нийт 164 хүнд 2 удаа мессэжээр хүргүүлэн ажилласан.

Арга хэмжээний хүрээнд Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, сумдын ЗДТГ-тай хамтран аймгийн хэмжээнд нийт архи, согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг 196 цэгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж холбогдох хууль, эрх зүйн актын хэрэгжилтийг шалгаж, 150ш санамж, зөвлөмжийг тарааж ажиллалаа. Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй 214 цэг байдгаас архи, согтууруулах ундаа худалдаалах 178, түүгээр үйлчлэх 36 цэг байна. Шалгалтаар үйлдвэрлэсэн огноог тэмдэглээгүй М-Ти-Эс ХХК-д үйлдвэрлэгдсэн 0,5л-ээр савлагдсан 2 ширхэг “Монгол Стандарт” архи, Герман

улсад үйлдэрлэгдсэн 1 литрын импортын Sangria дарсыг хураан авч, шинжилгээнд хамруулсан. Шинжилгээний дүнгээр стандартын шаардлагыг хангасан байв. Арга хэмжээний хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил, цаашид анхаарах сэрэмжлүүлэг мэдээллийг аймгийн удирдлага, захирал, эрхлэгч нар оролцсон шуурхай зөвлөгөөн дээр танилцуулж, “Булган аймгийн Цагдаагийн газар” facebook хуудас, сумдын Цагдаагийн хэсгийн цахим хуудсаар 44 мэдээлэл, 5 төрлийн сэрэмжлүүлэг шторк тухай бүр нь оруулж иргэдэд сурталчилан ажилласан. Аймгийн Стандартчлал хэмжил зүйн газар, Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Иргэний зөвлөл хамтран Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа 3 цахим тоглоомын газруудад хяналт шалгалт явуулсан. Арга хэмжээний хүрээнд “Аюулгүй тээвэр” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан сумдын ЗДТГ, Авто тээврийн газар, бусад аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран хяналтын пост, зам дагуу хяналт шалгалтаар ажиллаж нийт 585 машин шалгаж зөрчилтэй 109 жолоочийг 3,034,000 төгрөгөөр торгож, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 14 зөрчил илрүүлэн, 11 жолоочийн эрхийг хасч, 3 хүнийг 7-30 хоногийн хугацаатай баривчлуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх талаар санамж, сэрэмжлүүлэг тараалаа

Албаны галт зэвсэг тусгай хэрэгслийг 2017 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн А/30 тоот, 2017 оны 12 сард нийт ЦБҮА-ны код-136.4.2.-д заасаны дагуу 2 удаа цагдаагийн газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан галт зэвсгийн тооллогыг явуулан ажиллаж байна. Албаны зэвсэг дагалдах хэрэгслийг ЖА-ны өрөөнд тусгайлсан 3 төмөр сейфинд ПМ-61, АКМ-7, СВД-1, Жад-6, кабер-44, сүмбэ-21, 1)Л- 12-2, дохионы буу-2, хийн буу-3, АКМ маказин 7 ширхэгийг хийж лацдан хариуцлагатай зохицуулагчийн хяналтад хадгалж байгаа ямар нэг галт зэвсэг, хийн буу дутсан зөрчил гараагүй бүрэн тоологдсон.

ЦЕГ-ын даргын 2014 оны №239 дүгээр тушаалын дагуу галт зэвсгийг сейфнээс гаргаж өгөх үед цагдаагийн алба хаагч өөрийн хариуцсан зэвсгийг тусгай бүртгэлийн дагуу эзэмших картын хамт НХЖХАХАхлах байцаагчид өгөн дараагийн ажилд шилжин орох мөн зэвсгийг эргэж өгөх үед цэвэрлэгээ үйлчилгээ бүрэн бүтэн байдлыг шалгуулан гарын үсэг зуран хүлээлгэн өгөн ажиллаж байна.

Зэвсэг хэрэглэлийн хадгалалт, хамгаалалт, тавьж олгох, ашиглалт зарцуулалтанд хяналт тавьсан бүртгэлийг ЦЕГ-ын даргын 2014 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 239 дүгээр тушаалыг баримтлан НЖХАХАхлах байцаагч хариуцан хөтлөж өдөр тутам жижүүрийн офицерууд лацыг нүд үзэн хүлээлцэж хоногийн нөхцөл байдлын рапортоор тусган ажиллаж байгаа ба ямар нэг зөрчил дутагдал илрээгүй.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн Б/631 дүгээр тушаалаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ө.Нармандах нь 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Хамгаалалтын газрын тусгай хамгаалалтын хэлтсийн даргаар томилогдон тул цагдаагийн газрын албаны галт зэвсгийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ны өдөр албаны галт зэвсгийг хүлээлцэн ажиллав.

Цагдаагийн газрын албаны галт зэвсэг дагалдах хэрэгслийг ЖА-ны өрөөнд тусгайлсан 3 төмөр сейфинд ПМ-61, АКМ-7, СВД-1, Жад-6, кабер-44, сүмбэ-21, 1)Л- 12-2, дохионы буу-2, хийн буу-3, АКМ маказин 7 ширхэгийг хийж лацдан хариуцлагатай зохицуулагчийн хяналтад хадгалж байгаа ямар нэг галт зэвсэг, хийн буу дутсан зөрчил гараагүй бүрэн тоологдсон.

“Сар шинэ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан, шүүхээс хорих ял нь тэнсэгдсэн, ял хойшлогдсон, мөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байгаа хүмүүст хэсгийн байцаагч, мөрдөгч нараар хувийн хэрэгт баталгааг авч ажиллав.

Мөн “Булганы мэдээ” сонинд сар шинийн баярын бэлтгэл хангах үеэр хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхгүй байх талаарх сэрэмжлүүлэг нийтлүүлэн, аймгийн төвийн алба хаагчид “Тэгш хэм”-ийн системээр хуваарилсаны дагуу 69 алба хаагч нийт 1107 айл өрхөөр орж, баярын өдрүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг тарааж, баяр амралтын өдрүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагын дарга, эрхлэгч нарт 54 албан мэдэгдэл өгч, хэрэгжилтийг нь тооцож ажилласан. Мөн аймгийн ГХУСАЗЗ-ийн санхүүжилтээр 700 ш сэрэмжлүүлэг хэвлүүлэн худалдааны төв, зах, гүний худаг усан сан, дэлгүүр, шатахуун түгээх станц,

банк, аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийн самбарт байрлуулан, иргэдэд мэдээлэл сэрэмжлүүлэг хүргэсэн.

Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын алба хаагч, ажилчдыг олон нийтийн эргүүлд гаргах ажлыг зохион байгуулан батлагдсан хуваарийн дагуу малын гоц халдварт өвчний хороо цээрийн дэглэмийн үед давхардсан тоогоор 123 удаа 1645 хүнийг олон нийтийн эргүүлд ажиллуулж мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан бөгөөд олон нийтийн эргүүлд ажиллах хугацаанд 86 зөрчил илрүүлэн холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, 177 аж ахуйн нэгж, байгууллага, 184 иргэнд зөвлөгөө өгч, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн хуудсныг иргэдэд тараан өгч сурталчилах, гудамж талбайд гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулан ажилласан.

### **-Шүүгч, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр**

Булган аймгийн шүүх нь Эрүү, Иргэний хэргийн давж заалдах, мөн Эрүү, Иргэн, Захиргааны сум дундын шүүх, Шүүхийн Тамгын Газар гэсэн бүтэцтэй, 11 шүүгч, 25 захиргааны ажилтан нийт 36 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Шүүх хуралдааны ачааллын хувьд өнөөдрийн байдлаар 7 хоногт дунджаар Эрүүгийн 5-7, Иргэний 10-15, захиргааны 1, эрүү, иргэний давж заалдах шатны 1-2 хурал тус тус хуралдаж байна.

Шүүх, Шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн алба хаагчдын үйл ажиллагаанд ахлах байцаагчийн зүгээс биечлэн тогтмол хяналт тавьж, зохиосон ажлын дүн мэдээг тогтоосон цаг хугацаанд өдөр бүр Цагдаагийн Ерөнхий газрын Шуурхай удирдлагын төвд өгч байна. Ахлах байцаагчийн зүгээс цагдаагийн газрын “Хариуцлагатай ёс журмын эргүүл”-д 10 удаа томилогдон ажилласан бөгөөд алба хаагчдын ажлын сахилга хариуцлага, ёс зүй, цэрэгжилч дүрэмч ажиллагаа, харилцааны соёл, хувцаслалт зэрэгт тогтмол хяналт тавьж ажиллаа.

Мөн хамтын ажиллагааны хүрээнд шүүгч нарт харилцан хүндэтгэлтэй хандах зорилгоор алба хаагчдыг шүүгч нартай ёсолж хүндэтгэн харьцдаг харьцааг хэвшүүллээ.

2018 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны 24, анхан шатны эрүүгийн 193, иргэний хэргийн давж заалдах шатны 12, иргэний 269, захиргааны 8, эрүүгийн хянан магадлах 6 шүүх хурал тус тус хуралдаж, нийт 504 хуралд журам сахиулсан. Хуралдааны хамгаалалтын цагдаагаар 2 алба хаагч /давхардсан тоогоор/ 324 удаа, харуулын цагдаагаар 4 алба хаагч нийт 182 удаа буюу 4368 хүн цагийн ажил үүрэг тус тус гүйцэтгэх хугацаанд ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй. Олон холбогдогчтой, шийдвэрлэгдээгүй удсан хэргийн шүүх хуралдаан болоогүй байна. Шүүхээр үйлчлүүлж буй иргэдийн бичиг баримтыг шалган энгэрийн тэмдэг зүүлгэн, зохих журмын дагуу нийт 2684 иргэнийг нэвтрүүлэн ажиллаж, алба хаагчдын үйл ажиллагаанд ахлах байцаагчийн зүгээс тогтмол хяналт тавьж, үүрэгжүүлэн гүйцэтгэл, үр дүнг 7 хоног бүр тооцон ажиллаж байна.

2018 оны эхний хагас жилийн байдлаар албадан ирүүлэх, хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулж, удирдлагаар хангаж ажиллаа.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан 2016 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/40, 113 дугаар тушаалаар батлагдсан “Яллагдагчийг хуяглан хүргэх, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4,20 дахь хэсэгт “Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг үндэслэн албадан ирүүлэх ажиллагааг хэрэгжүүлсэн мэдээллийг цагдаагийн байгууллага нэгтгэн тухайн шүүхийн тамгын газар, шүүхийн ерөнхий зөвлөлд сар бүр хүргүүлнэ” гэж заасны дагуу 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт эрүүгийн хэргийн 2 гэрч, шүүгдэгч 2, иргэний хэргийн 7 хариуцагчийг албадан ирүүлсэн талаархи мэдээллийг сар бүрийн 30-ны дотор тус шүүхийн тамгын газарт хүргүүлэх ажлыг хэвшүүллээ.

Хуяглан хүргэх ажиллагааны хүрээнд дараахь ажлыг зохион байгууллаа. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан 2016 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/40, 113 дугаар тушаалаар батлагдсан “Яллагдагчийг

хуяглан хүргэх, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах журам”-ын 2 дугаар зүйлийг баримтлан үйл ажиллагаа гүйцэтгэсэн.

2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт /давхардсан тоогоор/ 116 яллагдагч, шүүгдэгч нарыг Шүүхээс Цагдан хорих байранд, Цагдан хорих байрнаас шүүхрүү хуяглан хүргэх үйл ажиллагааг холбогдох журмын дагуу Цагдаагийн газрын холбогдох албан тушаалтнуудад тухай бүрт танилцуулан, хэсгийн алба хаагчдаар ямар нэгэн зөрчил дутагдалгүй гүйцэтгүүлээ.

Харуулын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч О.Давааням 2018 оны 05 дугаар сард хорих 439 дүгээр ангид хянан магадлах хуралд шүүгч С.Цэрэндуламыг ажиллахад аюулгүй байдлыг хангаж ажилласан ба ямар нэгэн зөрчилгүй ажиллалаа.

### **-Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

2018 онд зохион байгуулах нэгдсэн болон тусгай арга хэмжээний төлөвлөгөөг гарган батлуулж, төлөвлөгөөний дагуу болон ЦЕГ-ын харъяа нэгжүүдээс ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу эхний 5 сард “Шинэ жил”, “Сар шинэ”, “Сар шинэ-Аюулгүй тээвэр”, “Согтуу”, “Хяналт”, “Хамтдаа шийдвэрлэе”, “Сэрэмжилье нэгдье”, “Хуулиа мөрдье”, “Хуулийн хэрэгжилт”, “Илрүүлэлт, Эрэн сурвалжлалт, Шийдвэрлэлт”, “Мотоциклийн бүртгэл”, “Бяцхан зорчигч”, “Хамгаалах бүс”, “Гар утас”, “Хүүхдээ хамгаалъя” зэрэг улсын хэмжээнд 8, аймгийн хэмжээнд 6, хэсэгчилсэн 7 арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.

Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4657 иргэнийг хамруулан сургалт, мэдээлэл 44, уулзалт хэлэлцүүлэг 5, өдөрлөг 12, уралдаан, тэмцээн 18 удаа тус тус зохион байгуулан ажиллалаа.

Булган аймгийн хэмжээнд “Сар шинэ-Аюулгүй тээвэр” нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийт 2569 тээврийн хэрэгсэл шалгаснаас 612 зөрчил илрүүлж 612 жолоочийг 14.105.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авч, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ сэргээхээр ирсэн 14 жолооч, нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг “Булган жолоо”, “Залман Хангай” зэрэг аж ахуйн нэгжүүдийн 20 жолооч, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 54 багш, ажилчдад “Миний жолоо” автокурсийн захирал Ш.Дуламсүрэнтэй хамтран Зөрчлийн тухай хууль, Зөрчлийн оноо тооцох журам, Замын хөдөлгөөний дүрмээр сургалтуудыг зохион байгуулж ажиллаа.

“Хуулиа мөрдье” арга хэмжээний хүрээнд Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, сумдын ЗДТГ-тай хамтран аймгийн хэмжээнд нийт архи, согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг 196 цэгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж холбогдох хууль, эрх зүйн актын хэрэгжилтийг шалгаж, 150ш санамж, зөвлөмжийг тарааж ажиллалаа. Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй 214 цэг байдгаас архи, согтууруулах ундаа худалдаалах 178, түүгээр үйлчлэх 36 цэг байна. Шалгалтаар үйлдвэрлэсэн огноог тэмдэглээгүй М-Ти-Эс ХХК-д үйлдвэрлэгдсэн 0,5л-ээр савлагдсан 2 ширхэг “Монгол Стандарт” архи, Герман улсад үйлдэрлэгдсэн 1 литрын импортын Sangria дарсыг хураан авч, шинжилгээнд хамруулсан. Шинжилгээний дүнгээр стандартын шаардлагыг хангасан байв.

Аймгийн Стандартчлал хэмжил зүйн газар, Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Иргэний зөвлөл хамтран Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа 3 цахим тоглоомын газруудад хяналт шалгалт явуулж, холбогдох хууль эрх зүйн акт, стандарт шаардлагын хэрэгжилт, хүүхдэд үзүүлж буй үйлчилгээ хэрхэн байгаа талаар шалгаж, зөвлөмж чиглэл өгч ажиллалаа.

“Аюулгүй тээвэр” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан сумдын ЗДТГ, Авто тээврийн газар, бусад аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран хяналтын пост, зам дагуу хяналт шалгалтаар ажиллаж нийт 585 машин шалгаж зөрчилтэй 109 жолоочийг 3,034,000 төгрөгөөр торгож, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 14 зөрчил илрүүлэн, 11 жолоочийн эрхийг хасч, 3 хүнийг 7-30 хоногийн хугацаатай баривчлуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх талаар санамж, сэрэмжлүүлэг тараалаа.

Цагдаагийн газрын 2017 оны үйл ажиллагааны тайлан тавих нэгдсэн арга хэмжээг Соёлын ордонд зохион байгуулан, иргэдэд хийсэн ажлаа танилцуулан, иргэдийн санал хүсэлтийг амаар болон саналын хуудсаар хүлээн авч ажилласан бөгөөд арга хэмжээний үеэр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвх зүтгэл гарган ажилласан Булган

сумын 4-р багийн иргэн Д.Мөнхөрмаа, 3-р багийн иргэн Д.Хишигдэлгэр, мөн Н.Баасанжаргал даргатай Тохижилт үйлчилгээний ангийг Цагдаагийн газрын баярын бичиг, үнэ бүхий зүйлээр тус тус урамшуулж, урлагийн хэсэгчилсэн тоглолтыг иргэдэд толилууллаа. Тайлан тавих нэгдсэн арга хэмжээний үеэр “Шар нохой жилийн хийморь” азтанаар 3 иргэнийг шалгаруулан Батламж, дурсгалын зүйлээр урамшуулж, иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчилсан шторк, цагдаагийн газрын үйл ажиллагааны видео тайлан зэргийг дэлгэцээр үзүүлэх, үйл ажиллагааны сурталчилгааны самбар, Цагдаагийн байгууллагад хэрэглэгдэж буй техник хэрэгсэл зэргийг байрлуулан сурталчлан ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9-р зүйлд заасны дагуу гэмт хэрэг, зөрчлөл 111-д хариу авсан бөгөөд хугацаа болоогүй 16 мэдэгдэл, мэдэгдлийн хариу авалт 95,7 хувьтай байна.

Булган суманд архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг 23 аж ахуйн нэгжүүдийн захирал, ажилчдад Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал, үйлдэж буй арга, газар, цаг хугацаа, субъект, хор уршигийн талаар мэдээлэл хийж уг төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгжүүдийн үүрэг хариуцлагын талаар сургалт явуулан баталгаа гаргуулан авсан.

Аймгийн төвд болон 5 суманд малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 38/01-309 албан тоотоор сумын нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахгүй байх талаар захирамж гаргуулах хүсэлтийг хүргүүлсэнээр тухайн сумдын Засаг даргын захирамжаар тодорхойгүй хугацаагаар архи согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчлэхийг хориглосон захирамж гаргуулж, аж ахуйн нэгжийн захиралуудад захирамжыг танилцуулан худалдан борлуулж байгаа архи согтууруулах ундааг тоолж лацдан борлуулахгүй байх баталгаа гаргуулах ажлын зохион байгуулсан. Дээрх захирамжийн хэрэгжилтэнд өдөр тутам хяналт тавьж, архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох тухай Булган сумын Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/55 дугаар захирамжийг зөрчиж, бусдад архи худалдсан Булган аймгийн Булган сумын 1-р багт байрлах “Хас” дэлгүүрийн эзнийг Зөрчлийн тухай хуулийн 15.2.1.3-т заасны дагуу 500,000 төгрөгөөр торгож хариуцлага тооцсон.

“Хуулиа мөрдье-21” арга хэмжээний хүрээнд “Эрсдэлээс хамтдаа сэргийлье” аяныг зохион байгуулан Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газар, Улаан загалмай нийгэмлэг, 2-р цэцэрлэгтэй хамтран Булган сумын хүнд нөхцөлд амьдарч байгаа 8 өрхийн 21 хүнд дулаан хувцас өгч, урьдчилан сэргийлэх эмчийн үзлэгт хамруулан 1 эмэгтэйн нийгийн асуудлыг шийдэж ажлын байраар хангаж, 2 хүүхдийг цэцэрлэгт хамруулж ажиллалаа.

Мөн “Эрсдэлээс хамтдаа сэргийлье” аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 8-9 дүгээр ангийн 158 охид, 68 хөвгүүдийг өсвөр үеийн эмчийн үзлэгт хамруулан, ерөнхий боловсролын сургуулийн орчинд багш, сурагчид гар утас, таблет хулгайд алдах, цахим орчинд донтох зэргээс урьдчилан сэргийлж аймгийн Боловсрол соёл урлагийн газарт санал хүсэлтийг хүргүүлсний үр дүнд аймгийн Боловсрол соёл урлагийн газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/01 дугаар тушаалаар хичээл сургалтын цагаар ухаалаг гар утас, таблет хэрэглэхийг хязгаарласан тушаал гаргаж, иргэдэд сурталчлан ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн дунд “Архигүй ирээдүй”, “Хулгайлах гэмт хэргээс сэрэмжилье” сэдэвт гар зураг, зохион бичлэгийн уралдаан, хууль эрх зүйн мэдлэгийг бататгах АХА, “Асуулт-хариулт” тэмцээн зэрэг ажилд аймаг, сумын ГХУСА33-өөс 420,000 төгрөгийн санхүүжилтээр тус тус зохион байгуулж, цахим хуудсаар сурталчлан ажиллалаа.

Орхон аймагт зохион байгуулагдсан Архангай, Булган, Баянхонгор, Орхон, Хөвсгөл аймгуудын Цагдаагийн газрын алба хаагч нар оролцсон “Гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх нь” онол практикийн бага хуралд тус газраас Мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч Л.Шинэбаяр шүүгчээр, ЗЦТ-ийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Г.Батхуяг, Хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Г.Оюунгэрэл, Мөрдөгч, цагдаагийн дэслэгч П.Алтантогтох, Эрүүгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч З.Итгэлбаяр нар илтгэл тавьж оролцсон. Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Г.Батхуягийн “Орон нутагт зам тээврийн

осол хэрэг бууруулах арга зам, тулгамдаж буй асуудал” сэдвээр тавьсан илтгэл хоёрдугаар байранд орж, улсын хэмжээний шалгаруулалтанд оролцсон.

“Хүүхэд хамгаалал” арга хэмжээний хүрээнд гэр бүлийн харилцаа, хандлага, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргууд, өсвөр насны хүүхдээс үйлдэж буй гэмт хэрэг, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилготой сургалтыг Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын газар, Иргэний зөвлөл, Эрүүл мэндийн төв, Хамтарсан багийн гишүүд хамтран сургалтыг 16 сумын 737 иргэдийг хамруулан зохион байгууллаа. Мөн ерөнхий боловсролын сургуулийн 1440 сурагч, цэцэрлэгийн 712 хүүхдүүдийг хамруулан “Хүчирхийлэл бидний нүдээр”, “Цахим донтолтоос хүүхдүүдээ хэрхэн хамгаалах”, “Өсвөр үеийнхний эрүүл мэнд”, “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” зэрэг сэдвээр тус сургалт, мэдээлэл хийж, 1150 ширхэг зурагт хуудас, санамж, зөвлөмжийг тараан ажилласан. Мөн сургуулийн сурагчдын дунд “Би үүнийг тэвчихгүй” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан, “Хүчирхийлэл бидний нүдээр” сэдэвт гар зургийн уралдааныг тус тус зарлан эхний 3 байранд орсон хүүхдүүдийг урамшуулж ажилласан.

### **-Замын цагдаагийн албаны чиглэлээр:**

2017 оны эхний 1 дүгээр улирлын байдлаар хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг, осол 6 бүртгэгдсэн байна.

2018 оны эхний 1 дүгээр улирлын байдлаар хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг 3 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 буюу 40 % буурсан үзүүлэлттэй байна.

2018 оны эхний хагас жилд нийт 5996 зөрчил илрүүлсэн. Үүнээс эрхийн үнэмлэхтэй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 111, эрхийн үнэмлэхгүй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 31, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 91, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 111 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар эрхийг хасаж 44,400.0 төгрөгөөр, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 91 хүнийг 18.200.0 төгрөг, эрхийн үнэмлэхгүй, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 31 хүнийг Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулан, бэлэн бусаар 5763 хүнийг 133.880.000 төгрөгөөр торгож, 179 тээврийн хэрэгслийг түр саатуулан ажиллалаа.

Хөвсгөл аймагт “Хөх сувд” мөсний баяр 02 дугаар сарын 23-25-ны хооронд зохион явагдахад их хэмжээний тээврийн хэрэгсэлийн урсгал явж байгаатай холбогдуулан Түлүүгийн даваанаас Уньт хүртэл 150 замд хөдөлгөөнт эргүүлээр 2 алба хаагчийг, Гуртын гүүрэн дээр 24 цагийн хяналтын постыг ажиллуулан орон нутгаас бүртгэлийн 1 ажилтан, хилийн цэргийн 086 дугаар бүхий заставаас 2 ахлагчийг томилуулан хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан.

Тус тасгаас тухайн өдөр томилгоотой байгаа алба хаагчдыг өглөө бүр 08 цаг 30 минут, орой 18 цаг 00 минутанд жагсааж, ерөнхий жижүүр болон ёс журмын хариуцлагатай эргүүлүүдээр үүрэг зааварчилга өгч үүрэг гүйцэтгүүлж байгаа ба хорио цээрийн дэглэмийн дагуу аймгийн хэмжээнд нийт 42 хяналтын цэг байгаагаас замын цагдаагийн алба хаагчид 11-н цэг аймгийн төвийн 3 постонд 7-10 хоногоор 7 алба хаагч, Рашаанд суманд 36-45 хоногоор 4 алба хаагч, Гурван булаг суманд 25 хоногоор 1, Хутаг-Өндөр суманд 14 хоногоор 1, Сайхан суманд 21 хоногоор 1 алба хаагч буюу ахлах зохицуулагч 1, зохицуулагч-3, цагдаа зохицуулагч 10 хяналтын цэгүүдэд үүрэг гүйцэтгүүлэн ажиллаж байна. Баяннуур суманд хэсгийн төлөөлөгч, цагдаа нартай ээлжлэн 24 цагаар байнгын постонд 1 зохицуулагч үүрэг гүйцэтгэж байна.

Тус тасгаас 3 дугаар улиралд урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.Үүнд:

“Булган АЗЗА” ТӨХК-д, “Шороо орд маининг” ХХК, “Цагдуултайн ундрага” ХХК, “Эрдмийн өргөө цогцолбор сургууль”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба”, “Булган хот тохижуулах анги”, “ЭБЦТС” ТӨХК, “Булган мээж”, “Их газар” ХХК-д гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замыг засуулах, тэмдэг, тэмдэглэлгээг сэргээх, нөхөн тавиулах чиглэлээр 13 мэдэгдэл, албан шаардлага өгч, мэдэгдлийн хариуг авч ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургуулийн 1, 2-р 12 жилийн сургуулийн 45 багш ажилчдын дунд Замын хөдөлгөөний дүрмийн сургалт, 10 хүртэлх насны хүүхдүүдийн эцэг эх, анги хариуцсан багш нартай уулзаж, 10 хүртэлхи насны хүүхдүүдийг Замын хөдөлгөөнд



харгалзах хүнгүйгээр оролцуулахгүй байх талаар баталгаа авч, сургалт зохион байгуулж ажилласан.

Аймгийн хэмжээнд зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр элэгдэж муудсан самбаруудыг сольж 1 ширхэг шинэ зурагт самбарыг АГХУСАЗЗ-ийн санхүүжилтээр хийж, байрлуулан ажиллалаа.

Өвлийн улирал эхэлж цас орсноос шалтгаалан автозамын зорчих хэсэгт халтиргаа гулгаа үүсэх, цасан болон шороон шуурганаас шалтгаалан зам орчны үзэгдэх орчин хязгаарлагдмал болох, байгалийн таагүй үзэгдлийн үед осол, хэргээс урьдчилан сэргийлж замын хөдөлгөөнд оролцогч жолооч, зорчигчдод санамж сэрэмжлүүлэг тараан, өвлийн улирлын дугуй тавьж хэрэглэхийг хөдөлгөөнт эргүүлд хяналт шалгалтын явцад алба хаагч нарт хууль эрх зүйн зөвлөгөө өгч, Булган аймаг дахь TV-9 салбар, FM-106.5, мэдээ мэдээлэл өгч ажилласан.

Хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Орхон, Хялганат тосгоны “Хараацай” Цэцэрлэг, Хутаг-өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд сургалтыг үр дүнтэй зохион байгуулж ажиллалаа.

Осол гэмтлээс хамтдаа сэргийлье сарын аяны хүрээнд ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгт эцэг, эх, анги удирдсан багш нарт сургалтыг 3 удаа орсон.

Улсын чанартай замын тэмдэг тэмдэглэлийг сайжруулах зорилгоор 01 дүгээр сарын байдлаар Рашаант, Баян-нуур, Дашинчилэн сумын төвийн замын тэмдэг, тэмдэглэгээг шинээр хийлгэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллаж байна

“Сар шинэ нэгдсэн” арга хэмжээний хүрээнд 7 заалт бүхий төлөвлөгөө гарган ЗЦТ-ийн дарга, цагдаагийн хошууч Ж.Эрдэнэ-Очир батлуулан гудамж замд хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж ирэнсэн зөрчил дутагдлыг газар дээр нь засуулж хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн гудамж замд хяналт шалгалтанд гарч ажиллах хугацаанд хууль бус нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг жолооч нарыг илрүүлэн тэднээс дахин зөрчил дутагдал гаргахгүй байх талаар баталгаа гаргуулан авч ажиллаж байна.

Тус тасгаас Булган аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрч байгаа болон аймгийн төв дотор хөдөлгөөнд оролцож байгаа нийт жолооч нарын тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангуулах, жолооч нарын гэрэл хэрэглэх соёлыг дээшлүүлэх зорилгоор жолооч нарт сургалтыг зохион байгуулж ажиллаа. Уг арга Улсын чанартай замын тэмдэг тэмдэглэлийг сайжруулах зорилгоор аймгийн засаг даргын А/54 тоот захирамжаар 2 дугаар сард замын тэмдэг тэмдэглэгээнд үзлэг шалгалтыг Тэшиг, Хутаг-өндөр суманд ажлын хэсэг байгууллагдаж ажиллалаа.

Булган цагдаагийн газар page хуудас 12 удаа, Орон нутгийн замын цагдаа page хаягт 13 удаа, Баян-нуур сумын тамгын газар page хаяг 2 удаа, Булган замын цагдаагийн тасаг facebook group-д 15 удаа сэрэмжлүүлэг болон хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааг иргэдэд хүргэж ажиллаж байна.

Булган сумын төвд байгаа гэрэлтүүлгийг 2018.02.14-ний өдөр Хот тохижилт үйлчилгээний ангийн инженер Дөлгөөнтэй хамтарч үзлэг шалгалтыг хийхэд нийт 624 гэрэлтүүлэг байхаас асч байгаа 478 гэрэлтүүлэг байсныг Хот тохижилт үйлчилгээний ангиар засварлуулж хэвийн үйл ажиллагаанд оруулсан.

Орхон-Булган, Булган-Хөвсгөл аймгуудыг холбосон авто замуудад цас ихээр орсонтой холбогдуулж үзлэг шалгалтыг Булган “АЗЗА” ТӨХК-ны ерөнхий инженер Мөнх-Эрдэнэтэй хамтран хийж шуурсан цэгүүдийн цасыг цэвэрлүүлж ажилласан.

Авто замын халтиргаа гулгаа, хаагдсан замын талаар тухай бүр нь Булган замын цагдаагийн тасаг, Орон нутгийн замын цагдаа хаяганд байршуулсан.

Булган сумын 5-р багийн нутаг Спортын ордноос эмнэлэгийн зүүн талын замтай холбох, Булган сумын 5-р багийн Мэргэжил сургалтын төвийн араас гэр хорооллын хөндлөн замтай холбож асфальтан зам тавих ажлуудыг Булган-АЗЗА ТӨХК-ны ерөнхий инженер Мөнх-Эрдэнэ, Булган сумын засаг даргын орлогч Оюунбат нартай уулзсан.

Булган аймгийн Булган суманд 3-н гэрлэн дохио байрладаг ба Булган сумын 5 дугаар багт баруун 4 замын уулзвар, холбооны 3 замын уулзвар, зүүн 4 замын уулзваруудад гэрлэн дохио ажиллаж байна.

Булган аймгийн төвд 54 цэгт 86 ширхэг камер байрлуулсанаас 10 камер засварлагдан одоо 44 камер ажиллаж 42 камер ажиллахгүй байна. Үүнээс Замын

хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих 10 камераас 6 камер ажиллаж 4 камер ажиллахгүй болсон байна

Булган-А33А ТӨХК-ны хариуцсан Булган сумын төвөөр дайран өнгөрч буй авто замуудын тэмдэгт үзлэгийг хийж шинээр 3 тэмдэг байрлуулах саналтай албан мэдэгдэл хүргүүлсэн.

Булган-А33А ТӨХК-ны ерөнхий инженер Мөнх-Эрдэнэтэй уулзаж Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Хүйтний гүүрэнд хайс хашлага хийлгэх санал 1 удаа өгсөн.

Булган аймгийн хэмжээнд ашиглагдаж буй 3 улсын чанартай авто замуудын хашлагын дагуух гэрэл цацруулагч муудаж бүдгэрсэн, мөн цацруулагч байхгүй газруудад цацруулагчтай болгож засварлах талаар Булган-А33А ТӨХК-нд албан мэдэгдэл хүргүүлсэн.

Булган-А33А ТӨХК-иар Бугат сумын Зоон даваа, Хутаг-Өндөр сумын Төлүүгийн давааны авто замын зорчих хэсгийн мөстсөн хэсгийг хусуулж цэвэрлүүлсэн.

Булган сумын 5-р багийн нутаг Спортын ордноос эмнэлэгийн зүүн талын замтай холбох, Булган сумын 5-р багийн Мэргэжил сургалтын төвийн араас гэр хорооллын хөндлөн замтай холбож асфальтан зам тавих ажлуудыг санал хүргүүлсэн.

Булган сумын төвд байгаа гэрэлтүүлгийг 2018.03.19-ний өдөр үзлэг шалгалтыг хийхэд нийт 624 гэрэлтүүлэг байхаас асч байгаа 582 гэрэлтүүлэг хэвийн асч байна.

Эрдэнэт-Булган, Булган-Хөвсгөл холбосон авто замуудад цас орсонтой холбогдуулж үзлэг шалгалтыг Булган-А33А ТӨХК-ны ерөнхий инженер Мөнх-Эрдэнэтэй хамтарч цас ихээр шуурсан цэгүүдийг 1 удаа хусуулж ажилласан.

Булган-А33А ТӨХК-д Замын эвдэрч тахийсан тэмдгийг засварлах талаар хүргүүлсэн. Цагдуултайн ундарга, шороон орд манинг ХХК -д “могойн гол”-ын уурхайгаас нүүрс тээвэрлэхдээ даац хэтрүүлж байгаа зөрчилд жолооч нарт хариуцлага тооцож дахин зөрчил гаргахгүй байх талаар албан мэдэгдэл өгсөн.

Авто замд халтиргаа гулгаа үүссэн болон нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний явц үр дүнгийн талаар Булган замын цагдаагийн тасаг, Орон нутгийн замын цагдаа хаяганд тус бүр 1 удаа байршуулсан.

Ачааны автомашин, ачаа тээвэрлэлт, Тусгай дууд гэрлэн дохио, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, өнгө үзэмж, Тээврийн хэрэгслийн улсын дугаар гэсэн арга хэмжээг зохион байгуулсан. Зөрчлийн тухай хуулийн 14.7.10.1-ээр 7 хүнийг 350,000 төг, 14.7.10.2-оор 315 хүнийг 15,750,000 төг, 14.7.10.3-аар 7 хүнийг 350,000 төг, 14.7.11.1-ээр 126 хүнийг 1,260,000 төг, 14.7.11.2-оор 218 хүнийг 2,180,000 төг, 14.7.11.3-аар 84 хүнийг 840,000 төг, 14.7.12-оор 10 хүнийг 250,000 төг, 14.7.13-аар 1 хүнийг 50,000 төг, 14.7.14-өөр 143 хүнийг 3,575,000 төг, 14.7.15-аар 1903 хүнийг 38,060,000 төг, 14.7.46-аар 10 хүнийг 1,000,000 төг, 14.7.47-гоор 191 хүнийг 9,550,000 төгрөгөөр тус тус торгох арга хэмжээ ногдуулсан.

### **Гурав: Дүгнэлт**

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх.

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/120 дугаар тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын баталсан “Эрүүл цагдаа” хөтөлбөр, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/127 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөр”-үүдийг хэрэгжүүлэх ажлыг шинэ түвшин гаргах.

Алба хаагчдын сургалт, соён гэгээрүүлэх ажил, бие бялдарыг хөгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах.

### **Дөрөв: Санал**

Цагдаагийн газрын барилга нь 1996 онд аж ахуйн аргаар баригдсан бөгөөд бүтэц, орон тооны хувьд тухайн үеэс 50 гаруй орон тоогоор нэмэгдсэн, мөрдөгч нар албан өрөөндөө 4-үүлээ, эрүүгийн мөрдөгч нар өрөөндөө 5-уулаа, Замын цагдаагийн ахлах

зохицуулагч, зохицуулагч нар 6-уулаа, Хэрэг бүртгэх тасгийн дарга, ахлах мөрдөгчтэйгээ, сэтгэл зүйч, захиргааны хэргийн болон мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн нар В-1 давхарт үүрэг гүйцэтгэж байгаа нь цагдаагийн газрын алба хаагч нарын албан үүрэг гүйцэтгэхэд хүндрэлтэй, албаны нууцлал, аюулгүй байдалд эрсдэл учирч, иргэдийн хууль ёсны эрх ашиг зөрчигдөхөд хүрсэн. Иймд өргөтгөлийн барилга барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх.

Зураг төсөл судалгааны Дархан Дизайн ХХК-наар 2017 онд Цагдаагийн газрын төв конторын барилгад нэмж өргөтгөл барихад шаардагдах 156.0 сая төгрөгийн өртөг бүхий зураг төсөв хийлгэсэн.

Орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсүүдэд сургалтын зардал шийдвэрлэж өгөх.

Боловсон хүчний бодлогод анхаарч орон нутагт ажиллаж байгаа хэрэг бүртгэх нэгжүүдийн орон тоог нэмэх

Рашаант сум дахь сум дундын цагдаагийн тасгийн цагдаагийн байр “кабон”-нь 2007 онд ашиглалтанд орсон бөгөөд урсгал засвар хийгдэх шаардлагатай болсон тул хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх.

ХЯНАСАН:

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

З.ГОМБО

ТАЙЛАГНАСАН:

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Г.БОЛДБААТАР

